Монгол улс ухаалаг бодлого явуулснаараа Москва, Бээжинтэй харилцах харилцааны шинэ үндсийг тавьж, саяхан олж авсан бие даасан байдлаа гадаад бодлогоороо бататгаж чадсан байна. Гэвч шинэ хараат байдал нэлээд дээр үеэс илэрч эхэлжээ. 2001 оны 9-р сарын 11-ний дайралтын дараа АНУ-д илүүтэй ойртох боломж гарсан нь эцэстээ Хятадын улам бүр хүчтэй болж байгаа нөлөөг тэнцвэржүүлэх зорилготой байсан буйзаа. Гэвч энэ гурван их гүрэнтэй харьцах түвэгтэй гурвалжингийн харилцаа [Юрген Каль]-нд нь өргөн цар хүрээтэй хамгаалалт хэрэгтэй байлаа. Гагцхүү ийм хамгаалалтыг буй болгосноор л чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломжтой байв. Монгол улс “Том тоглоомчин”-гуудтай харилцаж хамтран ажиллахын зэрэгцээ бүс нутагтаа болон түүнээс гадуур хоёр ба олон талт харилцааны аль болох нягт сүлжээг бий болгож байв. Чингэхдээ түншээрээ ардчилсан орнуудыг сонгож авсан. “Гуравдагч хөрш”-ийн үзэл баримтлалын дагуу сонгосон гол орнууд нь бүс нутагтаа Япон, Өмнөд Солонгос, бүсийн гадна ЕХ байсан, байсаар ч байна. Зөвхөн эдийн засгаа хөгжүүлэхийн тулд эдгээр орныг сонирхоогүй. Энэ нь ганцхан өөрөөсөө хамааралтай, өөрийн хүчээр өөрийгөө хамгаалах чадваргүй улс орны аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцсэн алхам юм. Монгол улс зөвхөн хязгаарлагдмал хэмжээнд нөлөөлж чадах ч өөрийнх нь язгуур эрх ашгийг хөндөхүйц зөрчилдөөн Төв болон Хойт Азийн төлөөх “great game”-д хэтдээ гарч болох талтай. Үүнд:

- Төв Ази, Монгол дахь АНУ-ын цэргийн нөлөө Орос, Хятадын эсэргүүцэлтэй улам бүр тулгарах боллоо. Монголыг НАТО-д ойртуулах санаа Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага (SCO)-д элсүүлэх хөрш орнуудын хүсэл сонирхолтой зөрчилдөж байна. Зүүн хойт ази дахь эрх мэдлийн шинэ дэглэм Монгол улс ямар байр суурь

баримтлахаас багагүй шалтгаалах болно.

- Орос, Хятад хоёр эрчим хүч, тээврийн дэд бүтцийн хоёр талын гэрээ хэлэлцээрт Төв Азийн жижиг улсуудыг үл оролцуулж, зөвхөн өөрсдийн үндэсний ашиг сонирхлоо харгалзан үзнэ гэдгээ өнгөрсөн хугацаанд харуулсан. Монголын ашигт малтмалын арвин нөөцийг ашиглах явцад голчлон улсын концернууддаа ашиглалтын эрх олгуулахын тулд Хятад, Оросын зүгээс ихээхэн дарамт шахалт үзүүлж болзошгүй гэсэн зовнил буй.

**2.** 1990 оноос зах зээл нээлттэй болж Монголын улс ардын аж ахуйд бүтцийн гүнзгий өөрчлөлт хийхэд хүргэсэн юм. ЗХУ буюу Орос улсаас татаас авдаг байсан импорт зогссоноор дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал, дэд бүтцийн сул тал тодорхой харагдах болжээ. Өнөөг хүртэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эрчим хүч импортлох хэрэгцээ шаардлага их хэвээр байна. Түүний хамтаар экспортынх нь нэр төрөл маш хязгаарлагдмал. Боловсруулах үйлдвэр сул хөгжсөн тул өртөг бий болгох үйл явц ихэвчлэн гадаадад явагдаж байна. Тиймээс эх орны баялаг хүн ардынхаа хүртээл болж бүрэн чадахгүй байна.

Эдийн засгийн энэ сул дорой байдал нь гадаад бодлогод зөрчилдөөн үүсэх нөхцөл болж байна. Учир нь газар зүйн байршлын улмаас худалдааны гол түнш нь Орос, Хятад хоёр байсан, байх ч болно. Монгол улсын гадаад худалдааны эргэлтийн 56 хувь нь Хятадад ногдож байна. Харин Орос улс эрчим хүч нийлүүлдэг тул импортод тэргүүлэх байрыг эзэлж байна. Монгол улсын гадаад худалдааны эргэлтийн зөвхөн 20 хувь нь ЕХ, АНУ, Японы дунд ногдож байна.

Гадаадын албан ёсны шууд хөрөнгө оруулалтаар Хятад 40 орчим хувиар маргаангүй түрүүлж явна. Зам тээврийн дэд бүтцэд хөрөнгө оруулснаар арвин баялаг ашигт малтмалаа Хятадын улс ардын аж ахуйн хөгжлийг хангахад зориулан нөөцлөх нөхцөл бүрдэнэ.

Тэрчлэн худалдаа, жижиг үйлдвэрлэлд ч Хятадын хил орчмын бүс нутгуудаас хүчтэй шахалт ирж байна. Энэ өрсөлдөөн зарим аймгийн хүн амын дургүйцлийг ихээхэн хүргэх болжээ. Нутгийн иргэдэд хөдөлмөр эрхлэх боломжийг хангалттай гаргаж өгөхгүй бол Хятадтай харилцах хоёр талын харилцаанд нэлээдгүй дарамт үүсч мэдэхээр байна.

Улс ардын аж ахуй, гадаад худалдаагаа мэдэгдэхүйц өргөтгөн хөгжүүлэхгүй л бол Монгол улс энэ хараат байдлынхаа улмаас

эдийн засгийн хориг арга хэмжээнд ихээхэн өртөмхий байх болно. Гадагшаа нээлттэй байхад шаардлагатай хуулийн ерөнхий нөхцөлийг бүрдүүлсэн. Гэхдээ олон улсын хөрөнгө оруулагчдад идэвхтэй үйл ажиллагаа явуулахад нь практик хүндрэл бэрхшээл учирсаар байна. Саянаас ашигт малтмалыг маш их сонирхох болсноор нь дулдуйдан энэ асуудлыг анзааралгүй өнгөрч болохгүй. Дүрэм журам, хуваарилалт, байгал орчны бодлогын асуудлуудыг шийдвэрлэсэн цагт ашигт малтмал нь Монголын эдийн засгийг хөгжүүлэхээр заяасан бэлэг ч болж болно. Тийм учраас эдийн засгийн бодлого талаас нь аваад үзвэл Монголд ирэх жилүүдэд бүтцийн өөрчлөлт хийхэд зайлшгүй хэрэгтэй түнш, туслан дэмжигч нь олон улсын гол хандивлагчид болох Япон, ХБНГУлс байх болно. Гагцхүү энэ нь биелэлээ олсон цагт хүчтэй “Гуравдагч” түншийг оролцуулсан тэнцвэртэй гадаад бодлогын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх боломжтой.

**3.** Хүчээр давамгайл хөрш орнууд улс орны бие даасан байдлыг алдагдуулж болдгийн сонгодог жишээ нь эхлээд харахад Монголд тохирно. Гэхдээ “уламжлалт бус аюулгүй байдал” хэмээн өнөө үед нэрлэх болсон хүчин зүйлсийг анхаарахгүй байж болохгүй. Манай түнш улс орнуудын дунд байрладаг дамжин өнгөрөх орон тул шинэ аюул заналд өртөж мэдэхээр байна.

Монгол орны хосгүй авч өртөмхий экосистемд бүс нутаг, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт эмзгээр тусч байна. Уламжлалт амьжиргааны үндэс удаан хугацаагаар алдагдах буюу сүйдэж, албадан шилжилт хөдөлгөөний хор уршиг Монгол болон түүний хилийн чанадад өнөөдөр илрэх болжээ. Одоо болтол ул мөр төдий байгаа угсаатан хоорондын зөрчил ялангуяа шашны тулгуур үзлээр дэмжигдэх юм бол Хятад болон Төв Азийн хилийн орчимд аюултай хэмжээнд хүртлээ хурцдаж болно. Алан хядах үйл ажиллагаа харин Монголыг тойрч ирэв.

Эндээс манай түнш орны ирээдүйн гадаад бодлоготой холбоотой ямар дүгнэлт гаргаж болох вэ?

Ардчилагдаж буй Монгол оронд эхэн үедээ бүс нутаг буюу дэлхийн хэмжээнд өөрийн үйл ажиллагааг тодорхойлж тодорхой үүрэг гүйцэтгэх түүхэн гарц байсангүй. 20-р зуунд бие даасан байдал нь алдагдсан байсан тул гадаад бодлогын зарчмаа тодорхойлж, практикт турших орон зай байсангүй. Тийм учраас тогтвортой стратегийн үзэл баримтлал боловсруулах туйлын өндөр зорилт тэргүүлэх

улс төрчдийн өмнө тавигдаж байна. Энэ нь том, жижиг хөрш орнуудынх нь баримталж буй чиг баримжаанаас ялгарсан үзэл баримтлал байх ёстой гэдгийг би энд харуулахыг зориллоо. Гэхдээ энэ ялгамжаатай байдлыг улс орон болон бүс нутагт олдож буй боломж хэмээн ойлгож ч болно. Үүнд:

1. Түүх, соёл иргэншил талаас нь аваад үзвэл Төв Азийн лал болон турк хэлтэн орнуудад зуучлах, тэнцвэржүүлэх замаар нөлөөлөх нөхцөл бололцоо Монголд байна. Төв Азийн олон үндэстэн ястан, соёлын хүрээнд шинэ санаа солилцох гол үүргийг Монгол улс гүйцэтгэж болно. Энэ бүс нутагт тулгуур үзэлтний янз бүрийн урсгал оршин байгаа тул Монголын буддизмийн зүгээс үзүүлэх хүлээцтэй тайван нөлөөг нөлөөг дутуу үнэлж болохгүй. Хөрш орнуудад цөөнхийн зөрчил, салан тусгаарлах үзлийг дэвэргэхгүй байхад энэхүү нээлттэй байдал ч бас хамаатай.
2. Монгол улс нь яриа хэлцээ хийх төвийг сахисан газрын хувьд Хойт Солонгосын асуудлаархи хэлэлцээнд чухал үүрэгтэй. Мөн түүхийн явцад хөгжиж ирсэн харилцаа нь ч нөлөөтэй. Зүүн хойт Азийн хямрал нь энэ бүс нутагт хамтын ажиллагаанд тулгуурласан аюулгүй байдлын шинэ бүтцийг яаралтай бий болгох явдал чухал байгааг харуулав. Монгол нь жижиг орон тул бүс нутгийн ноёрхлыг интеграцчлахад идэвхтэй үүрэг гүйцэтгэлээ хэмээн сэжиглэгдэхгүй. Монголын дипломатууд энд сүүлийн жилүүдэд хямралын менежментийн үнэтэй туршлагыг хуримтлуулж чадсан. Ардчилсан хоёр түнш Япон, Өмнөд Солонгос идэвхтэй хамтран ажиллахад бэлэн буй.
3. Монгол улс нь бүс нутгаасаа алсад ч тэнцвэржүүлэх нөлөө үзүүлж чадна. Үүний тулд хөршүүдтэйгээ харилцах харилцааны даацтай үндэс суурь тавигдсан байх ёстой. Хэрэв тэгж чадвал АНУ, Хятадын харилцаанд тэнцвэржүүлэгч үүрэг гүйцэтгэж чадна. Түүнээс гадна Өмнөд Азийн үзүүлэх ач холбогдол нэмэгдэж, тэр дундаа Энэтхэг улс хөгжин дэвшихийн хэрээр улс гүрнүүдийн байр суурь шинэчлэгдэж байна. Хамгийн сүүлд Афганистаны хямралаас хойш Энэтхэгийн гадаад бодлого Төв Азид нэвтрэхэд улам бүр чиглэх боллоо. Соёлын шижмээр холбогдсон Өмнөд Азитай харилцахад

Монгол улс цаашдаа илүүтэй анхаарах хэрэгтэй юм.

Өөрийнх нь цэрэг, эдийн засгийн нөөц бололцоо хязгаарлагдмал тул илүү чадавхитай бүс нутгийн эвсэл холбоотой нягт хамтран ажиллах шаардлагатай. Үүнд АСЕАН, ЕХ зэрэг лавтай орно.

4. 1990-ээд оны үеэс Монгол улс олон улсын хэд хэдэн чухал байгууллагад элссэн, тухайлбал Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк (ADB), Дэлхийн худалдааны байгууллага (WTO), хамгийн сүүлд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (SCO). НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол улс цэргээ илгээн оролцож ирэв. Харин Монгол улс олон улсын байгууллагуудад хэр амжилттай ажиллах нь улс орныхоо дотоод дахь шилжилтийн үйл явцыг хэр амжилттай урагшлуулж, нөөц хүчээ дайчлан хөгжүүлэхээс мөн хамаарна.

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нар аа!

Эцэст нь дээр ярьсан зүйл маань Германы гадаад бодлогын зорилт, арга хэрэгслүүдэд ямар ач холбогдолтой болох талаар хэдэн үг хэлэхийг зөвшөөрнө үү!

БНХАУ, Орос улсын геостратегийн хүчний төвд, Дундад Азийн лалын орнуудтай орон зайн хувьд ойр дөт байдгаараа Монгол улс онцгой байр суурийг эзэлж буй хэмээн Германы улс төрийн хүрээнийхэн санал нэгтэй үзэж байгаа юм. Герман улс Монгол улсын Европ руу гарах гарц болохын хувиар өнгөрсөн хугацаанд амжилттай үйл ажиллагаа явуулж ирлээ. Герман нь Монголтой хамгийн сайн харилцаагаараа хүлээн зөвшөөрөгдсөн ЕХ-ны гишүүн орон юм. ЕХ-ны 2013 оныг хүртэлх Монголын талаархи стратегийн баримт бичигт өргөн цар хүрээтэй стратегийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд ЕХ нээлттэй байгааг онцолсон байна. Монгол улс Европын холбоо нь үндэсний болон хамтын идэвх санаачлагыг сайтар уялдуулсаны үндсэн дээр үр бүтээлтэй ажиллаж чадна.

Гэхдээ Монгол улсын хүч бололцоог бодитой харгалзах ёстой. Тийм учраас (гадаад) бодлогын өөр бусад чиглэлийг тодорхойлохдоо хамтын ажиллагааны тодорхой чиглэлүүдтэй холбож өгөх хэрэгтэй, тухайлбал аюулгүй байдал, гадаад бодлогын салбар, уур амьсгал, байгаль орчны асуудлыг аюулгүй байдал хэмээх өргөн утгаар нь авч үзэх зэрэг. Гэхдээ гагцхүү бүтцийн хүндрэлтэй асуудлуудаа good governance—н утгаар нь авч үзсэнээр эдгээр үүсгэл санаачлага хэрэгжих боломжтой. Төв Азиар зогсохгүй бусад оронд ч үлгэр

дууриал үзүүлэх нөөгдмөл хүч Монгол улсад бий гэдгийг ЕХ зүй ёсоор онцолдог. Нэн ялангуяа гадаад бодлогын чадавхийг улам нэмэгдүүлэх шаардлагатай.

Албан ёсны дипломат үйл ажиллагаа нь өргөн хэлхээ холбоо, иргэдийн идэвх санаачлагаар дэмжигдэж байх ёстой. Тийм учраас би энд Монгол-Германы чуулганыг цаашид хоёр талын яриа хэлцээний гол индэр болгон үргэлжлүүлж, бэхжүүлнэ хэмээн Ерөнхий нарийн бичгийн дарга Штаудахерийн хэлснийг дахин давтан хэлэхийг хүсч байна.

Та бүхнийг сонирхон сонссонд их баярлалаа.

*Др. Проф. П.Очирбат  
Монгол улсын Ерөнхийлөгч асан,  
МГЧ-ны Ерөнхийлөгч*

## **Монгол-Европын харилцааны байдал**

Ландтагийн Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Др.Штайнеке  
Эрхэмсэг ноён В. Штаудахер  
Энэхүү бага хуралд оролцож байгаа эрхэмсэг хатагтай ноёдоо

Монгол-Германы чуулганы 6 дугаар бага хурлыг өөрийн байранд зохион байгуулах дэмжлэг үзүүлсэнд Заксен-Анхалт мужийн удирдлагад юуны өмнө талархлаа илэрхийлье.

Монгол-Германы харилцааг дэмжих зорилгоор 1999 онд байгуулагдсан Монгол-Германы чуулган төрийн бус байгууллагын үйл ажиллагааг байнга дэмжин 6 дахь удаагийн бага хурлыг зохион байгуулж байгаа Конрад Аденауэрийн Сангийн удирдлага, сангийн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён В.Штаудахер Танд талархалаа мөн илэрхийлэхийг хүсч байна.

Монгол Германы чуулганы болон Монгол Германы харилцаа хамтын ажиллагааны талаар элэгсэг дотно үг хэлсэн ноён Д.Штайнеке, КАС-ын ЕНБД ноён В.Штаудахер нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Бага хурлын хөтөлбөрт хэлэлцэх асуудлын дагуу “Монгол Улс ба Их гүрнүүдийн стратегийн сонирхол” сэдвээр сонирхолтой илтгэл тавьсан Конрад-Аденауэр Сангийн Дэд Ерөнхийлөгч бөгөөд Хемниц хотын их сургуулийн олон улс судлалын тэнхимийн профессор хатагтай Б.Нойсс Танд талархал илэрхийлж баяр хүргье.

Монгол-Германы чуулганы Ерөнхийлөгчийн хувьд Монгол-Европын харилцааны тухай цөөн хэдэн үг хэлэх хүндтэй үүрэг оногдсонд баяртай байна.

Би өөрийн илтгэлийн сэдэв рүү орж ярихын өмнө Др.Проф. хатагтай Б.Нойсс-ын илтгэсэн сэдэвтэй холбогдуулж зарим санал бодлоо илэрхийлэхийг хүсэж байна.

Монгол Улс бурханаас заяагдсан хоёр том хөрштэй. Хөршөө сонгодоггүйн зарчмаар бид олон зууны турш айл зэргэлдээ хаяа нийлэн амьдарч байгаа билээ. Түүхийн урт хугацаанд бид их гүрний статусыг ээлжлэн эдэлж явлаа. Эзэн Чингисийн үед Монгол Улс их гүрэн байлаа.

Эдүгээ цагт Орос, Хятад хоёр их гүрэн байна. Бид өөр хоорондоо дайн дажингүй, тайван амгалан, найрсаг харилцаатай зэрэгцэн оршиж байгаадаа сэтгэл хангалуун байдаг юм.

Цагийн аясаар их гүрнүүдийн стратегийн сонирхол өөрчлөгдөж байсан боловч ардчилал, даяаршиллын өнөө үед бидэнд газар нутгийн болон соёл иргэншлийн маргаантай асуудал байхгүй.

Монгол Улсын Гадаад бодлогын тэргүүлэх чиглэл бол хоёр хөрш орон ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг хөгжүүлэх бодлого байдаг.

Монгол Улс 1992 онд ОХУ-тай, 1993 онд БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан бөгөөд хоёр хөрш маань “Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг” дэмжиж цөмийн зэвсэгтэй таван орны хамтын баталгаанд гарын үсэг зурсан болно.

Одоо энэхүү баримт бичгийн эрх зүйн баталгааны гэрээ байгуулахаар гурван тал ажиллаж байна.

ОХУ Монгол Улсын зөвхөн Ази дахь хөрш төдий бус Европ, Ази тивийг дамжин оршдог учир Монгол-Европын харилцаанд ч онцгой үүрэгтэй байдаг.

1990-ээд оны эхээр Монгол-Оросын харилцаа зарим талаар сулрах хандлага гарах болсонд нөлөөлсөн хэд хэдэн зүйл байсан байх.

1. Монгол Улс ОХУ-ын цэрэг улс төрийн холбоотон байхаа больсон,
2. ЗХУ задарч Монгол Улс урьдын адил техник, эдийн засгийн тусламж үзүүлэх боломж хязгаарлагдсан,
3. Геополитик, гео эдийн засгийн шинэ нөхцөлд өрнөдийн орнуудтай холбоо тогтоох, дасан зохицох бодлого тэргүүн ээлжинд тавих болсон,
4. Оросын монгол судлаач эрдэмтэн Сергей Лузянины хэлснээр:” Монгол нь ЗХУ-ын хувьд Ази Африкийн орнуудад үзүүлж харуулах баримт байхаа больсон. Өөрөөр хэлбэл Монгол Улс Зөвлөлтийн үзэл суртлын маш чухал зорилтыг хэрэглүүлэгч байхаа больсон байна.

Эдгээр болон бусад хүчин зүйлээс шалтгаалан Орос Улс Монголоос хөндийрч байсан байх. Одоо байдал өөр болсон. Монгол, Оросын харилцаа хамтын ажиллагаа өргөжиж хөгжиж байна.

Монгол Улс БНХАУ-ын харилцаа Улс төр, эдийн засаг, соёл боловсролын олон салбарт өргөжиж байна. Хятад улсын эрчимтэй хөгжлийг Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хүчин зүйл болгож, өөрийн давуу талыг ашиглан эрх тэгш хамтран ажиллах нь Монголын геоэдийн засгийн бодлогын гол чиглэлийн нэг байх ёстой юм.

БНХАУ-ын стратегийн сонирхолыг татах Монголын давуу талын нэг бол эрдэс баялагийн их нөөц юм. Монголд чиглэсэн Хятад Улсын стратегийн бодлого ч ийм хандлагатай байх гэж бодож байна.

Монгол Улс хоёр хөрш орон ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцаа хөгжүүлэх бодлого баримтлаж байна.

Монгол Улсын гадаад бодлогын нэг чухал чиглэл бол гурав дахь хөршийн тухай бодлого юм. Гурав дахь хөршийн бодлогын гол агуулга нь геополитикийн гэхээсээ геоэдийн засгийн чиглэлийг түлхүү анхаарч хөгжүүлэхэд байгаа юм.

Гурав дахь хөрш гэдэг бол аль нэг орныг онцгойлон сонгож хэрэглэхдээ гол нь биш гео эдийн засгийн системд хамтран ажиллаж байгаа улс, гүрэн тэдгээрийн нэгдлийг гэж бид ойлгодог юм.

Энэ утгаараа АНУ бол манай гурав дахь хөрш. Үүнийг АНУ-ын Ерөнхийлөгч ноён Жорж Буш Монгол Улсад айлчлахдаа нотолсон.

Европын холбоог бид гуравдахь хөршөө гэж үздэг.

Япон, Солонгос, Энэтхэг улсуудыг бид гуравдахь хөршөө гэж хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна.

### **Монгол Европын харилцааны талаар**

Түүх яривал Монгол Улс Европтой аль эрт XIII зууны үеэс орчим харилцаатай байсан баримтууд олон бий.

Өнгөрсөн зуунд Зүүн Европын орнуудтай Эдийн засгийн харилцан туслалцах Зөвлөлийн хүрээнд хамтын ажиллагаа хөгжүүлж байлаа.

Эдгээр орнуудын ихэнх нь өнөөдөр Европын холбооны гишүүн болсон байна. Энэ бол өмнөх үеийн харилцааны сайн туршлагыг үргэлжлүүлэх таатай нөхцөл бүрэлдэж байна гэсэн үг.

1990 оноос хойш Монгол Улс Европын улс орнуудтай, ЕХ-той харилцах харилцаанд асар их өөрчлөлт орлоо.

Хүйтэн дайны үе дуусгавар болж, 1990 онд Монгол Улсад ардчилсан өөрчлөлт эхэлснээр Монгол Улс нээлттэй, бие даасан гадаад бодлого явуулах боломжтой болсон бөгөөд энэ үеэс чухамхүү Монгол Улс-Европын хоорондын харилцааны шинэ үе эхэлсэн хэмээн үзэж болно.

1990-ээд онд Европын улсуудын интегралчлал улам нягтарч, улмаар Зүүн Европын хуучин социалист орнууд ч ЕХ-нд нэгдсэнээр Монгол-Европын харилцааг үндсэндээ Монгол-ЕХ-ны харилцаа тодорхойлох болсон.



Иймээс би Монгол Улс ЕХ-ны харилцааны талаар хэдэн тоо баримт хэлэхийг хүсч байна.

Монгол Улс 1989 оны 8 дугаар сарын 1-ний өдөр ЕХ-той албан ёсны харилцаа тогтоосон.

Харилцааны эрх зүйн үндсийн хувьд

- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Хэлэлцээр, 1992 онд,
- Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн худалдаалах тухай Хэлэлцээр, 1995 онд (1998 онд энэ хэлэлцээрийн хугацааг сунгасан).
- Европын хөрөнгө оруулалтын банктай хамтран ажиллах Ерөнхий хэлэлцээр, 1997 онд
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүнээр 2000 онд элссэн.

Монгол Улс 1992-1993 онд ЕХ-ны АЛА хөтөлбөрт, 1994-2006 онд ТАСИС хөтөлбөрт, 2006 оноос дахин АЛА хөтөлбөрт хамрагдаж байна.

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу хамтарсан хороо байгуулагдаж, одоогийн байдлаар 9 дүгээр хуралдаанаа өнгөрсөн 9 дүгээр сарын 21-нд Брюссельд хийгээд байна. Худалдаа, хөрөнгө оруулалтын дэд хороо мөн ажиллаж болов.

Монгол улсаас ЕХ-ны гишүүн орнуудтай хийж байгаа худалдаа нь манай улсын гадаад худалдааны нийт эргэлтэд 2000-2003 онуудад 10%, 2004 онд 15.7%, 2005 онд 11.1%-ийг тус тус эзэлж, манай улсын хувьд Европын Холбоо /ЕХ/ нь Хятад, ОХУ, АНУ-ын дараа орох дөрөвдөгч том худалдааны түнш байв.

Харин Монгол Улсын ЕХ-ны гишүүн орнуудтай 2006 онд хийсэн гадаад худалдааны барааны нийт эргэлт 230 сая ам.доллар болсноор **"Европын Холбоо нь Монгол Улсын гадаад худалдаанд 7.8%-ийг эзэлж**, БНХАУ (нийт худалдааны 47.9%), ОХУ (19.6%),-ын дараа АНУ (5.4%), Япон (3.5%) –ны өмнө худалдааны 3 дахь түнш болжээ.

Монгол Улсын нийт экспортын 10% нь ЕХ-ны орнуудад ногдог бөгөөд эдгээрээс Германи, Итали ба Их Британи улсууд нь худалдааны гол түнш орнууд болоод байна. 2006 онд ЕХ-нд 108,2 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн экспортолсны 81,4 сая ам доллар нь буюу 75 орчим хувийг алт, самнасан ноолуур эзэлж байна.

Монгол Улс- ЕХ-ны нийт худалдааны эргэлтийн 1/3 орчим нь ХБНГУ-д ноогдож буй нь Герман Улс нь зөвхөн улс төр, хөгжлийн тусламж, хүмүүнлэгийн харилцааны хүрээнд бус мөн эдийн засгийн салбарт ч Европ дахь Монгол Улсын тэргүүлэх түнш болсныг харуулж байна.

Хөрөнгө оруулалтын хувьд 1990 оноос хойш Европын Холбооны 23 орноос Монгол Улсад оруулсан нийт 100.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэнээс ХБНГУ 14.5 сая ам.дол., Итали 13.5 сая ам.дол., Португал 13.5 сая ам.дол., Бельги 5.1 сая ам.дол., Нидерланд 6.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар тэргүүлж байна.

Европын Холбооны нийт хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах салбарт буюу ноолуурын салбар тэргүүлж, банк, санхүүгийн үйлчилгээ, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, ашигт малтмалын эрэл, хайгуул, олборлолт, харилцаа, холбоо болон хөнгөн үйлдвэрийн салбар зонхилж байна.

Гэвч Монгол Улсад оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр эхний байруудад БНХАУ, Канад, БНСУ, АНУ, Япон, ОХУ орж, ЕХ-ны орнуудаас ороогүй байгаа бөгөөд Европын Холбооны хөрөнгө оруулалтын байдлыг ерөнхийд нь дүгнэж үзвэл бололцооны хэмжээнээс доогуур байна гэж үзэж байна.

### **Монгол-ЕХ-ны харилцааны стратегийн ашиг сонирхолын тухайд**

Европын интегралчлалын үйл явц хурдацтай өрнөж, Гадаад болон аюулгүй байдлын нэгдсэн бодлого баримтлах болсоноор ЕХ нь дэлхийн улс төр, эдийн засгийн голлох төвүүдийн нэг бөгөөд энэ нь Монгол Улс- ЕХ-ны харилцаанд зарчмын шинэ бөгөөд чанарын өөрчлөлт орох үндэс болсон гэж хэлж болно.

Товчоор хэлбэл нэгдсэн Европ нь Монгол Улсын стратегийн ашиг сонирхолд шууд нөлөөлөхүйц хүчин болсон хэмээн хэлж болох бөгөөд гурав дахь хөршийн тухай Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд Монголын тал ЕХ-той 3 дахь хөршийн хэмжээнд хамтран ажиллахыг сонирхож байна.

Монголын тал 1992 онд ЕХ-той байгуулсан Хэлэлцээрийг өргөтгөн Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах замаар энэхүү сонирхолоо бататгахыг эрмэлзэж



байна. 2007 оны 9 дүгээр сард Брюссельд болсон Монгол-ЕХ-ны Хамтарсан комиссын хуралдааны үеэр ЕХ-ны Гадаад харилцаа эрхэлсэн комиссар хатагтай Ферреро-Валднер ЕХ-ны зүгээс Монгол Улстай Түншлэлийн хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн явдал Монгол-ЕХ-ны дараагийн шатны харилцааг тодорхойлох чухал үйл явдал болсныг тэмдэглэхийг хүсч байна.

Монголын тал 2007 онд ЕХ-ноос батлаад буй Төв Азийн бодлогын үзэл баримтлалыг анхааралтай судлаж буй болно.

### **Монголчуудын хувьд Европ гэж юу вэ, ЕХ-ноос юу хүсэн хүлээж буй талаар**

- Монгол Улс ЕХ-той 3 дахь хөршийн хэмжээнд харилцаж, Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжиж хамтарч ажиллахыг хүсч байна.
- Дэлхийн орлогыг бүрдүүлэх болон хувиарлах үйл хэрэгт Монгол Улс өөрийн орон зайг эзлэхэд ЕХ-ны дэмжлэгийг хүсч байна.

Энэ зорилгод хүрэхэд ЕХ-той байгуулах Түншлэлийн хэлэлцээр улс төр болоод эрх зүйн чухал үндэс суурь болох учиртай.

- Техник, технологи өндөр хөгжсөн Европын орнуудаас суралцах, технологийн транспер хийхийг хүсч байна.
- Орос, Хятадын зах зээлд гарах хамгийн ойр газар зүйн онцлогоо ашиглан Европын хөрөнгө оруулалтыг татах, улмаар боловсруулах үйлдвэр байгуулж, баялаг бүтээхийг зорьж байна.
- Европын хэл, соёлтой ойр дотно танилцахыг хүсч буйн илрэл нь Монгол Улсын ерөнхий боловсролын болон их, дээд сургуульд сонголтын журмаар гадаад хэл судлаж буй оюутан, сурагчдийн тоогоор англи хэл тэргүүлж, герман хэл 4 дүгээр байранд орж байна.

### **Монголчууд Европчуудын хувьд ямар түнш байж чадах вэ?**

- Түүхэн үүднээс Европын томоохон гүрнүүд Монгол Улсыг геополитикийн хувьд сонирхож байсан .Тухайлбал

алдарт Great game гэсэн ухагдахуунд Түвд, Төв Азиас гадна Монгол ч орж байсан билээ.

- Өнөөдөр Монгол Улс улс төр, эдийн засаг, нийгэм, сэтгэл зүйн шинэтгэлийг зэрэг хийх хүнд сорилтыг амжилттай туулж өөрийн гэсэн өвөрмөц өнгө төрхийг бүтээж байна. Ардчилсан Монгол Улс Төв Ази болон Азийн бусад орнуудын хувьд загвар болж, ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо нь хүн төрөлхтөний нийтлэг зам бөгөөд Азийн зарим орны удирдагчид ярих дуртай Азийн зам байхгүй гэдгийг нотлоход түүхэн чухал үүрэг гүйцэтгэж чадна
- Шашин болон соёл иргэншлийн зөрчилдөөн нэмэгдэж буй өнөө үед буддын шашинтай, нүүдлийн соёлтой Монгол Улс болон христосын шашинтай, суурьшмал соёлтой Европын харилцаа нь соёл иргэншил, шашин хоорондын яриа хэлэлцээ, солилцоо явуулах загвар болох боломжтой
- ЕХ-ны улсууд Төв Азийг эрчим хүчний хувьд стратегийн түнш хэмээн үзэж буй бол нүүрс, уран, зэс болоод орчин үеийн аж үйлдэрийн бусад түүхий эдийн арвин нөөц бүхий Монгол Улс аж үйлдвэржсэн ЕХ-ны хувьд геоэдийн засгийн чухал түнш байх боломжтой
- Эрчимтэй хөгжиж буй Зүүн Ази, хятадаас Европ хүрэх агаарын болон төмөр зам, авто зам дайран өнгөрөх чухал транзит бүс нутаг болох боломжтой бөгөөд энэ утгаараа Монгол Улс транзит тээврийн чухал үүрэгтэй
- Монгол Улсын эрчимтэй хөгжиж буй эдийн засаг нь Европын техник, технологийг худалдаж авах бодит зах зээл болон хөгжиж байна.
- Монгол Улс Европын жуулчдын зочлох таатай бүс болон хөгжиж байна.

### **Дүгнэлт**

ЕХ нь Монгол Улсын гадаад бодлогод 3 дахь түншийн хэмжээнд харилцах гол түншүүдийн нэг бөгөөд Монгол-Германы иж бүрэн түншлэлийн харилцаа энэхүү харилцааны гол хөтөлөгч хүчин болж буй хэмээн дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

*Проф. Чанг Бин*

*Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Орос,  
Зүүн Европ, Дундад Азийн хүрээлэн, Бээжин*

## **Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын харилцаа, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсын талаар явуулж буй бодлого**

**А.** Хятад, Монголын харилцааны тойм,  
Хятадаас Монголын талаар явуулж буй  
бодлого

Монгол Улс Азийн төвд оршдог, далайд гарцгүй орон юм. Тус орон умард талаараа Орос улстай хиллэдэг. Зүүн, өмнөд, баруун талаараа Хятадтай хиллэдэг. Хятад, Монголыг 4.676 километр урт хил холбодог. Монгол Улс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын умард дахь чухал хөрш юм. Монгол Улс Хятад, Оросын завсарт оршдог. Монгол улс нь газар зүйн өвөрмөц байршилтай.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс нь Монгол Улстай 1949 оны 10-р сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон. Хэдийгээр хоёр орны харилцаанд нэлээд зөрчил гарч байсан боловч хоёр орон голчлон сайн хөршийн ёсоор харилцаж ирэв. Сүүлийн 10 жилд хоёр орны найрсаг, сайн хөршийн харилцаа онцгой хурдацтай, амжилттай хөгжиж ирлээ. Улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, цэргийн г.м. салбарт найрсаг хөршийн хамтын ажиллагаа байнга бэхжиж, улам хөгжсөөр ирлээ. “Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын найрсаг хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд 1994 онд хоёр орон дахин гарын үсэг зурсанаар эрүүл, тогтвортой харилцааны улс төр, эрх зүйн үндэс тавигдсан. Дипломат, албан болон энгийн паспорттай иргэд албан ажлаар харилцан визгүй зорчдог болсон.

Хоёр орны консулын харилцаа сайжирсан нь харилцан худалдаа хийх, иргэдийн солилцоонд чухал дэмжлэг болсон юм.

Хятад улс нь Монгол Улсын худалдааны хамгийн гол түнш, хамгийн их хөрөнгө оруулагч болоод байна. Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа нь ашиг малтмал олборлох, бүтээн босголтын ажилд голлон төвлөрч байна. Хоёр орны харилцаа эхний үед эдийн засгийн харилцаагаар эхэлж, улмаар улс төрийн харилцан ойлголцлоор дэмжигдэх болсон. Хоёр орны улс төрийн харилцаа сайжирснаар эдийн засгийн хамтын ажиллагаа урагшилсан. 1998, 2003, 2004 онуудад БН Хятад Ард Улс, Монгол Улсын хамтарсан Тунхаглалыг баталсанаар дээд хэмжээний төлөөлөгчдийн харилцан айлчлалын замыг нээж өгсөн. Ийм олон удаа дээд хэмжээний харилцан айлчлал хийх, Тунхаглалуудыг олон нийтийн хүртээл болгох явдал нь тус хоёр улсын хувьд ховор тохиолдол байсан юм. Тухайн тунхаглалыг нийтлэх бүрт эдийн засгийн хамтын ажиллагааны олон хэлэлцээр, хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд гарын үсэг зурагдаж байв. Энэ нь хоёр орны улс төрийн хамтын ажиллагаагаар эдийн засгийн хамтын ажиллагааг амжилттай хөхиүлэн дэмжсэнийг харуулж байна. БН Хятад Ард Улс, Монгол Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа нь хилийн худалдаанаас эхэлж, бүх нийтийг хамран, хөрөнгө оруулалт, санхүүгийн хамтын ажиллагаа болтлоо хөгжсөн юм. Нэг үгээр хэлбэл БН Хятад Ард Улс, Монгол Улстай эрүүл, сайн харилцаатай байна.

Хятадын Засгийн газар урьдын адил биеэ даасан, хараат бус, энх тайванч гадаад бодлогыг явуулж байна. “Хятад улс газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг

харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай хамтран ажиллах, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр дэлхийн бүх оронтой найрсаг хамтын ажиллагааны харилцааг бий болгон хөгжүүлэхийг эрмэлзэж байна". Хятадын Засгийн газар "Хөрш орнууд анд нөхөд", "Хөрш орнууд түнш" гэсэн гадаад бодлогын чиг шугамыг тууштай мөрдөж байна. "Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын найрсаг хамтын ажиллагааны тухай гэрээ"-ний 1 дүгээр зүйлд "Гэрээт талууд газар нутгийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтлох, бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай хамтран ажиллах, энх тайвнаар зэрэгцэн орших гэсэн энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр хоёр орны хооронд сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлнэ" хэмээн заасан байдаг. 1998, 2003, 2004 оны БН Хятад Ард Улс, Монгол Улсын хамтарсан гурван тунхаглалд Хятадын Засгийн газар Монгол Улсын биеэ даасан байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэж байгаагаа тодорхой илэрхийлсэн байдаг. Хятадын Засгийн газар Монгол Улстай харилцахдаа сайн хөршийн бодлогыг тууштай мөрдөж байна. Хятад улс Монгол Улсын биеэ даасан, тусгаар тогтносон байдал, Монголын ард түмний хөгжлийн хэтийн төлөвөө сонгох сонголтыг хүндэтгэж байна. Хятад улс цөмийн зэвсгээс ангид бүсийн талаархи Монгол улсын Засгийн газрын байр суурийг хүндэтгэж, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагууд, Ази, Европын бага хуралд оролцон ажиллах Монголын Засгийн газрын хүсэлтийг дэмжиж байна. Монгол Улс Азийн Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын ажиглагч болсонд Хятад улс чин сэтгэлийн баяр хүргэж байна. Монголын талаар БН Хятад Ард Улсын явуулж буй бодлогын цөм нь Монгол Улстай сайн хөршийн харилцааг хөгжүүлэх, хилийн бүс нутгуудад тогтвортой байдал, энх тайвныг сахих, үндэсний цөөнхийн амьдардаг бүс нутгуудыг хөгжүүлж, тогтворжуулахад оршино. Энэ нь Хятадын Засгийн газрын зах хязгаар нутгийн талаархи бодлогын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

**Б.** Хятад, Монголын харилцаанд таагүй нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйлс:

- а. Зарим монголчууд Хятадыг мэддэггүй, тэрч байтугай Хятадаас сэрэмжилдэг. Энэ нь Хятад, Монголын найрсаг

харилцааг хөгжүүлэхэд саад тотгор болдог.

Монгол улс нэлээд удаан хугацаагаар Зөвлөлт Холбоот Улсын хяналтанд байсан нь Хятад, Монголын харилцааны хөгжлийг маш их хязгаарлаж байв. Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа Хятад, Монголын харилцаа мэдэгдэхүйц сайжирсан. Удаан хугацааны сөргөлдөөн нь энгийн монгол, хятад иргэд харилцан танилцаж, ойртон дотносоход ихээхэн саад учруулсан. Монголчууд Хятадаас болгоомжилж, тэрч байтугай Хятадтай харилцах, хамтран ажиллахдаа сэрэмжилдэг хэвээр байна. Монгол Улс нь Хятад, Орос хоёрын дунд оршдог далайд гарцгүй орон гэдгийг дахин дурьдмаар байна. Тус орон "Нэг талыг баримтласны" хор уршгийг амссан хуучны туршлагаасаа гүн сургамж авч, 20-р зууны 90-ээд оноос "Олон тулгуурт" гадаад бодлогыг явуулж эхэлсэн. Монгол улс эдийн засгийн дэмжлэг авахын тулд АНУ, Япон, Герман болон барууны бусад оронтой харилцаагаа идэвхжүүлэхэд ихээхэн анхаарахын зэрэгцээ хоёр том хөрш Хятад, Оросын хувьд тэнцвэртэй гадаад бодлогыг явуулж ирсэн юм. Хятадтай тогтоосон эдийн засгийн харилцаа улам өргөжиж, Хятадын цагаачид орж ирснээр хятадчилагдах вий хэмээн зовнидог цөөн хүмүүс байдаг. Хятад хүчтэй, Монгол харьцангуй сул дорой байгаа нь бодит үнэн. Сул нь хүчтэйгээсээ ямагт болгоомжилж байх хэрэгтэй. Хятад, Монголын хамтын ажиллагаа нь эдийн засгийн хамтын ажиллагаанаас эхлэлтэй бөгөөд эцсийн буух цэг нь ч мөн л эдийн засгийн хамтын ажиллагаа байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа байнга өргөжин хөгжсөнөөр хятад, монгол иргэд ойртох боломжтой болно. Монгол улсын геополитикийн хүчин зүйлс төрийнх нь аюулгүй байдлын стратегийг тодорхойлж байна. Гадаад бодлогын сонголт нь ч бас бодит хүчин зүйлээр хязгаарлагдсан. Хоёр том орон болох Хятад, Оросын дунд оршиж буй Монгол Улс хоёр том хөршийнхөө аль нэгний холбоотон болж болохгүй хоёр том хөршийнхөө аль нэгнийг дайснаа хэмээн үзэж ч болохгүй. "Монгол улс Оростой харилцаагаа хөгжүүлснээр улс төрийн тогтвортой байдлаа хадгалж, Хятадтай харилцаагаа хөгжүүлснээр эдийн засгийн тогтвортой байдлыг олж авах хэрэгтэй" гэж нэгэн эрдэмтэн хэлсэн байдаг. Хэдийгээр Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагаанд оролцож байгаа боловч зөвхөн ажиглагч улс бөгөөд хууль ёсны үүрэг хүлээгээгүй. Тиймээс Хятад, Монголын хамтын ажиллагааны тогтвортой механизмыг бий болгож, Хятад,

Монголын хоорондын уламжлалт найрамдлыг хөгжүүлэх хэрэгтэй байна.

- б. Хятад, Монголын харилцааг хөгжүүлэхэд саад тотгор болж байгаа гол асуудал бол Тайваны асуудал юм.

Монгол Улс албан ёсоор урьдын адил БНХАУ бол нийт Хятадыг төлөөлөх цорын ганц хууль ёсны Засгийн газар гэж хэлдэг. Тайван бол Хятадын нутаг дэвсгэрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг. Хятадыг нэгтгэх чиг шугам, “Хоёр нийгмийн байгуулал бүхий нэг улс систем”-ийг дэмждэг. Тайваны тусгаар тогтнолыг дэмжихгүй гэдэг. Гэвч Тайваны “Мөнгөний бодлого”-ын дайралт нь түүнийг амлалтаасаа буцахад хүргэсэн юм. 2002 оны 6-р сард Монгол улсын нийслэл Улаанбаатарт Тайваны Эдийн засаг, худалдааны төв, Тайваны Эдийн засаг, соёлын төвийг байгуулахыг зөвшөөрсөн. Мөн оны 7-р сард Монгол Улс, Тайван хоёр төлөөлөгчийн газраа харилцан нээх албан ёсны баримт бичигт гарын үсэг зурсан. 9-р сард нь Улаанбаатарт Тайваны төлөөлөгчийн газар албан ёсоор нээгдсэн. 11-р сард нь Монгол Улс, Тайваны хооронд ажиллах хүч солилцоход хамтран ажиллах тухай гэрээнд гарын үсэг зурсан. 12-р сард Монгол Улсын Эдийн засаг, худалдааны төлөөлөгчийн газар Тайбейд албан ёсоор нээлтээ хийсэн. Монголын Засгийн газар Тайвантай харилцаагаа хөгжүүлэхдээ эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс хандаж байгаа нь илт.

- в. Хятад улс өөрийн аюулгүй байдлын үүднээс Монгол улсыг Хятадыг боомилох хүсэлтэй цөөн их гүрний гүүрний тулгуур багана болгохыг хүсэхгүй байна

Монгол Улс зүүн, баруун, өмнөд талаараа Хятадтай хиллэдэг. Хилийн шугам нь нийтдээ 4676 километр бөгөөд Умард Хятадын төв хэсгийг дайран үргэлжилдэг. Хятад, Монголын хилийн шугамын 700 километер хэсэгт Хятадын талд умард Хятадын стратегийн гурван бүс байдаг, тухайлбал зүүн хойт хятад, хойт хятад, баруун хойт хятадын стратегийн бүс. Эдгээр бүс нь стратегийн гол цэгүүд, зүүн хойноос баруун хойш явсан тээврийн гол замд маш ойр. Үүнд тухайлбал Жиүкуаны хиймэл дагуул хөөргөх төв, Таижуаны хиймэл дагуул хөөргөх төв, Лансиний төмөр замын шугам г.м. орно. Хятад, Монголын хилийн шугаман дээрх Зименвуде хотоос Хятадын нийслэл Бээжин хүртэл агаараар ердөө л 600 километр зайтай. Энэ нутагт батлан хамгаалахад дутагдах зүйл бараг байхгүй. Танк, моторт цэргийн ангиуд өглөө

нь гараад л орой нь Бээжинд хүрнэ. Хятад, Зөвлөлт Холбоот Улсын харилцаа хурцадмал байх цагт Зөвлөлт Холбоот Улс Монголтой хамтран сая сая цэрэг бүхий ангиудыг Хятад, Монголын хилийн дагуу байрлуулж умард Хятадын хил орчмын нутгуудад заналхийлж байв. Одоо Монгол улс нь Хятадын талаар явуулж байгаа ялгавартай бодлогынхоо чиг хандлагын улмаас нэг бол умард Хятадын аюулгүй байдлыг хамгаалах хана хэрэм, эс бөгөөс Хятадад аюул занал учруулж байгаа харийнхны бааз болж болохоор байна. Хэрэв Монгол Улс Хятадын талаар найрсаг бодлого явуулбал Умард Хятадад Оросын хүчнүүд шууд муу нөлөө үзүүлэхээс сэргийлж Хятад, Оросын дундах жийрэг болж болохсон. Харин Монгол Улс нэг л өдөр АНУ тэргүүтэй НАТО-той хамтарвал Умард Хятадын хилийн аюулгүй байдалд ноцтой сорилт, аюул занал учрахаар байна. Тийм учраас үүгээр миний бие Монгол Улс Умард Хятадын хилийн аюулгүй байдалд чухал гадаад бүс байсан бөгөөд Хятадын стратегийн газар зүйн байршилд онцгой чухал гэдгийг хэлэх гэсэн юм.

Хүйтэн дайны дараа барууны зарим гүрэн эдийн засгийн аргаар Монголд нэвтэрч, түүний хамт өөрсдийн үзэл суртал, соёл, цэргийн нөлөөг дэлгэрүүлж байна. Ийнхүү тэд энэ бүс нутагт аюулгүй байдал, тогтвортой байдлын тогтворгүй хүчин зүйлсийг авчирчээ. Тиймээс Монгол улстай сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны харилцааг бүх талаар хөгжүүлэх нь Хятадын гадаад бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ямагт болж ирэв. Хятадын хүсч байгаа стратегийн зорилго бол Монгол Улс гадаад бодлогын ямар ч стратеги баримталлаа гэсэн Хятадад хор хүргэхгүй байх явдал юм.

**В. Өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлснээр БН Хятад Ард Улс, Монгол Улсын хооронд найрсаг, сайн хөршийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс суурийг тавина**

**а. БН Хятад Ард Улс, Монгол Улс эдийн засгийн бүтэц, ашигт малтмалын салбарт харилцан бие биенээ нөхөж маш амжилттай хамтран ажиллаж чадна**

1. Худалдааны бараа таваарын бүтцэд харилцан бие биенээ нөхөж Хятадын аж үйлдвэр, нэн ялангуяа хөнгөн үйлдвэрт шинэчлэлт хийх, гадагшаа нээлттэй болох тал дээр эрс урагшлан хөгжлөө. Сайн чанарын сонголт ихтэй барааг боломжийн үнээр нийлүүлэх болов. Тэгвэл Монголын аж үйлдвэр хоцрогдсон, тоног төхөөрөмж нь хуучирсан байна. Монголын хөнгөн



үйлдвэрийн хэрэглээний бараа бүтээгдэхүүн одоо импортоос бүрэн хамааралтай байсаар байна. Хятад, Монгол хоёр нь ойрын хөрш орнууд тул хятадын барааны тээврийн хөлс харьцангуй бага байдаг. Хятадын өргөн хэрэглээний бараа Монголын хэрэглэгчдийн таашаалыг их хүлээдэг. Хятад бол хөдөө аж ахуйн том орон юм. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр үйлдвэрлэдэг, тэр нь сонголт ихтэй байдаг. Монгол Улс амьжиргааны үндэс нь мал аж ахуй байдаг. Хятадын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь Монголын зах зээлийн хэрэгцээг хангаж чадна.

## 2. Ашигт малтмалын салбарт харилцан бие биенээ нөхөж ажиллах нь

Монгол Улс ашигт малтмалаа төлөвлөгөөтэй ашиглаж иржээ. Ойрын ирээдүйд газар тариалан, барилгын материал, малын гаралтай бүтээгдэхүүн, аялал жуулчлал, газрын тос болон бусад ашигт малтмалыг хамтран ашиглах боломжтой. Дунд болон алсын ирээдүйд бэлчээр, ой, бусад ашигт малтмалыг хамтран ашиглаж болно. Монгол Улс нь 80 сая мал маллаж болох нэг сая гаруй км<sup>2</sup> бэлчээрийн талбайтай боловч одоогоор дөнгөж гуравны нэгийг нь ашиглаж байна. Монгол улс 130 гаруй сая куб метр мод, 16,5 сая тонн нүүрстэй. Зөвхөн Дорноговь, Өмнөговь дахь газрын тосны нөөц 400 сая тоннд хүрээд байна. Шинэчлэлтийн шатанд Хятадад ашигт малтмалын нөөц дутагдалтай байна. Хэрэв Хятад улс Монголд технологи, хөрөнгө санхүүгийн тусламж үзүүлж Монголын өмнөд бүсийн газрын тосны нөөцийг ашиглахад тусалбал энэ зуунд түргэн хурдацтай хөгжиж байгаа Хятадын эдийн засагт шаардлагатай байгаа газрын тосны импортын асуудал зарим талаар шийдэгдэнэ, учир нь зам богино, өөрийн өртөг бага, тээврийн таатай нөхцөл зэрэг ашигтай тал их байна. Энэ нь ашигт малтмалаа валютаар солих Монгол Улсын удаан хугацааны стратегид ч нийцнэ.

## 3. Ажиллах хүч, технологийн салбарт харилцан бие биенээ нөхөх

Хятадад ажиллах хүч илүүдэлтэй байдаг бол Монголд ажиллах хүч дутагдалтай байдаг. Барилгын томоохон төслүүд дээр ажиллах хүч, техникчид байнга дутагдаж байна. Хятадаас ажиллах хүч авснаар Монголын ажиллах хүчний дутагдлыг арилгахад тус болох боломжтой. Бүгд Найрамдах Монгол Ард Улс одоо ямааны ноолуур үйлдвэрлэгч 2 дахь том орон болоод байна. Гэвч тоног төхөөрөмж хуучирсан, технологи хоцрогдсон зэргээс болж ноолуурыг түүхийгээр нь гаргаж байна. Хятад

улс хангалттай ажиллах хүч, зохих технологийг оруулж, нөөцийг янз бүрийн хэлбэрээр ашиглахад хамтран ажиллах хүсэлтэй байна.

Монгол улсын Үндэсний статистикийн газрын мэдээгээр 1990-2005 онд 4814 гадаадын зуун хувийн хөрөнгө оруулалттай буюу хамтарсан хөрөнгө оруулалттай компани байгуулагдаж, 78 орноос нийт 875,3 сая ам. долларын хөрөнгө оруулалтыг татсан байна. Нийт оруулсан хөрөнгийн 47,4 хувь нь хамгийн том хөрөнгө оруулагч Хятадад ногдож буй. Канад 12,2%, Өмнөд Солонгос 7,3 %, Япон 5%, АНУ 3.6 %, Орос 3,2 %-иар дараах байруудыг эзэлж байна. Гэвч Хятадын Худалдааны яамны статистик мэдээгээр бол 2006 оны эхэн хүртэл Хятад улс 2166 төслийн хүрээнд 681 сая ам. долларыг Монголд оруулжээ. Үүний 360 саяыг ашигт малтмал хайгуул ашиглалт, 150 саяыг худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ, 29,29 саяыг барилга, барилгын материалын үйлдвэрлэл, 23,69 саяыг хөнгөн үйлдвэр, 23,82 саяыг хүнс, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлд оруулсан байна. Хэдийгээр статистикийн мэдээллүүд харилцан адилгүй байгаа боловч Хятад улс Монголд хамгийн том хөрөнгө оруулагч болж байна.

Хятад, Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд ямар тулгамдсан асуудал байгааг хоёр тал мэдэж байгаа. Монголын талд дэд бүтцийн хөгжил хоцрогдонгүй байна. Банк, зээлийн систем боловсронгуй болоогүй. Улс төрийн залгамж халаа дутагдалтай. Хятадын хувьд компаниуд голчлон удаан хугацааны төлөвлөгөөгүй ажиллаж байна. Учир нь жижиг, дунд үйлдвэрүүд худалдааны салбарт гол үүргийг гүйцэтгэсээр байгаа юм. Тэдгээр нь бүтээмж багатай, тэр бүр стандартын дагуу ажилладаггүй. Эдийн засгийн салбарт хамтран ажиллахдаа эдийн засаг, худалдааны бүтцийг алхам алхмаар зохицуулж, Хятад, Монголын харилцааг урагшлуулан хөгжүүлэхийн тулд геополитикийн сайн тал, эдийн засгийн салбарт харилцан бие биенээ нөхөх боломжоо өргөн ашиглах саналыг дэвшүүлж буйг минь болгооно уу.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжихдээ хүндрэл бэрхшээлтэй тулгарсан. Хятад улс чадлынхаа хэрээр сайн дураараа найрсаг тусламж дэмжлэг үзүүлсэн. Статистикийн бүрэн бус мэдээгээр Хятад улс нь Монгол Улсад 1991-2003 онд нийт 727 сая юанын дэмжлэг үзүүлсэн байна. Үүний 130 сая нь хүүгүй зээл байв. 200 сая нь хөнгөлөлттэй зээл, үлдсэн нь буцалтгүй тусламж юм. Сүүлийн хоёр жилд Хятад улс эдийн засгийн хүчин чадал бэхжихийн хэрээр жил бүр Монгол

Улсад дунджаар 80 сая юанын тусламж үзүүлж ирлээ.

**б. Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөтгөх**

1. Хятадад ирж суралцах Монгол оюутнуудын урам зоригийг бадраах хэрэгтэй. 1952 оноос тус хоёр орны боловсролын солилцоо эхэлсэн. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт солилцоо, хамтын ажиллагаа саад бэрхшээлгүй явагдаж байна. 1996 онд хоёр тал “БН Хятад ард улс, Монгол Улсын боловсролын салбарын 1996-2000 оны солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. 1998 онд хоёр тал “БН Хятад ард улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд боловсролыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай” гэрээнд гарын үсэг зурсан. 2000 онд хоёр тал Хятадад монгол оюутнуудыг сургахад Хятадын талаас хүүгүй зээл олгох төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Хятад, Монголын хөгжлийн түвшинд тодорхой зай байгаа өнөөгийн нөхцөлд монгол оюутнуудыг Хятадад сургах нь Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тустай төдийгүй хоёр орны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд ашигтай. 2002-2003 онд Монгол улс нийт 180 оюутан, давтан сургалтад хамрагдах оюутнуудыг Хятадад албан ёсоор илгээжээ. 2005 оноос энэ тоо 220 болж нэмэгдсэн байна. Хятадын 15 оюутныг Монголд давтан сургалтад хамруулжээ. Хятад хэлний нэг багшийг Монголд томилон ажиллуулсан байна. Үүний зэрэгцээгээр Өвөр Монголын өөртөө засах орны Засгийн газар жил бүр 100 монгол оюутанд тэтгэлэг олгон сургаж, хятад хэлний 30 багшийг Монголд томилон ажиллуулжээ.
2. Хятад болон Монгол Улс нь хятад судлалын боловсролын ажлаа эрчимжүүлж хоёр орны хамтын ажиллагааг хэрэгжүүлэх залуучуудыг бэлтгэх нь чухал байна. Сүүлийн жилүүдэд Монголд 30 хятад сургууль байгуулагдсан. Хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа байнга өргөжихийн хэрээр Монгол улсад хятад хэлийг сайн мэддэг төдийгүй эдийн засаг, худалдааны ажлыг амжилттай эрхлэх мэргэжлийн боловсон хүчин улам бүр их хэрэгтэй байна. Нийгмийн хэрэгцээг хангахын тулд хятад хэл сурах

залуучуудыг хоёр улсын Засгийн газар зоригжуулан дэмжиж байна.

3. Өөрсдийн бүс нутгийн хамтын ажиллагаа, хөгжлийг урагшлуулахын тулд БН Хятад Ард Улс, Монгол улс нь олон улсын болон бүс нутгийн асуудлаар хамтын ажиллагаагаа улам эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Түүнээс гадна хоёр орны Засгийн газар цаашдаа боловсрол, аялал жуулчлал, байгаль хамгаалал, эрүүл ахуй, халдварт тахал өвчнөөс сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа цаашид улам эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Берлин хот, 2007 оны 10-р сарын 16



*Шинжлэх ухааны доктор, профессор. Д.Мягмар  
Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал*

## **ДАЯАРШИЛ БА МОНГОЛ УЛСЫН ГАДААД ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ: ТОМ ГҮРНҮҮДИЙН СТРАТЕГИЙН АШИГ СОНИРХЛЫН ДУНД**

Эрхэмсэг ноён даргаа  
Ноёд, хатагтай нар аа

Юуны өмнө Ази ба Монгол улсад тулгарч буй шинэ нөхцөл байдал сэдвээр ярих боломж олгосон Конрад-Аденауэр Сангийн удирдлага энэхүү чуулганыг зохион байгуулагчдад талархлаа илэрхийлмээр байна. Энэ сэдэв маань маш өргөн хүрээтэй сэдэв юм. Би өөрийн илтгэлдээ Ази тивд бий болж буй шинэ нөхцөл байдалд тулгуурласан олон улсын харилцааны өөрчлөлтүүд түүнд Монголын Засгийн газар судлаачдаас өгсөн дүгнэлтүүд, Европын Холбоо, Шанхайн Хамтын Ажиллагааны байгууллага тухайн бүс болон дэлхийн бусад улсууд БНХАУ, ОХУ-тай хандах Монголын улс төрийн зорилтын асуудлуудыг хөндөж ярьмаар байна. Энэ сэдэвтэй холбогдуулан товч мэдээлэл өгмөөр байна.

### **Дэлхий нийтийн олон улсын байдлын өөрчлөлт.**

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, улс хоорондын харилцаа, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр тэлэн өргөжиж байна. Энэ үйл явц дэлхий нийтийн шинж чанартай болж улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгож байна.

Үүний сацуу цаг хугацааны хүчин зүйлтэй өрсөлдөн явагдаж буй дэлхий нийтийг хамарсан эдгээр өөрчлөлт янз бүрийн үүдэл шалтгаан бүхий шийдвэрлэгдээгүй олон

асуудлыг араасаа дагуулж буй нь улам бүр тодорхой болж байна.

Түүнчлэн хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, олныг хамрсан цагаачлал, эмх замбараагүй дүрвэлт, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд нүүрлэсэн шинэ аюул занал болж хувираад байна.

Уламжлалт бус аюул занал иргэд, хувь хүмүүсийн төдийгүй, улс гүрнүүдийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон дэлхий нийтийн аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй оролцоотойгоор, тэр дотроо олон улсын зэвсэгт хүчин, хууль сахиулах байууллагуудын нэгдсэн чармайлтаар хангах асуудал олон улсын харилцааны нэг гол зангилаа асуудал болон тавигдах боллоо.

### **Ази, Номхон далайн бүс нутгийн олон улсын байдлын ерөнхий хандлага.**

Ази, Номхон далайн бүс нутгийн олон улсын байдал сүүлийн жилүүдэд ерөнхийдөө тогтворжих шинж чанарыг агуулах боллоо. Энэ

нь дэлхий нийтийг хамарсан эрс өөрчлөлт, бүс нутагт болж буй үйл явдлуудын аль алиных нь үр дүн юм.

Үүний зэрэгцээ “Европын нийтлэг” мэт ойлголт Ази, Номхон далайн бүс нутагт өнөө хэр бий болоогүй байна. Энэ бүс нутгийг хэд хэдэн салбар бүс нутаг болгон зааглан үзэж болох бөгөөд одоогоор тэдгээрийн дотор зөрчил, маргаантай асуудлаа энхийн замаар шийдвэрлэх, улс төр, эдийн засгийн салбарт ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгох чармайлт ид явагдаж байна.

Энэ хүрээнд Хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлт нь анхаарч үзэх нэг хүчин зүйл болж байна. АНУ, ОХУ-ын улс төр, эдийн засгийн нөлөө Азид зарим талаар суларч түүний оронд эдийн засгийн эрчимтэй хөгжилд тулгуурласан Хятад улсын оролцоо өсөж байгаа нь сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Энэ нь Хятадад байнгын дарамт үзүүлж байсан ЗХУ задран тарснаар болон лалын ертөнц бүхэлдээ АНУ, ОХУ-ын хараанаас гарч байгаагаар нөхцөлдөх бөгөөд үүнээс үүдэн Ази, Номхон далайн бүс нутагт өөртөө ашигтай эдийн засаг, цэрэг-улс төрийн байр суурь эзлэх бололцоо Хятадад бий болж буйтай холбоотой байж болох талтай.

### **Бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын үндсэн асуудлууд.**

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын аюулгүй байдал ноцтой хүндрэх, томоохон зөрчил сөргөлдөөн үүсэх магадлал бага байна. “Хүйтэн дайн” төгсгөл болж, дэлхийн хоёр том туйлын нэг алга болсон гэхэд энэ бүс нутгийн аюулгүй байдлын орчинд хүчний тэнцвэр алдагдахад хүргэхээр ноцтой өөрчлөлт ажиглагдаагүй болно.

Гэхдээ энэ нь Ази, Номхон далайн бүс нутагт улс хоорондын харилцааны тогтвортой байдлыг хангах асуудал чухал болохыг үгүйсгэсэн хэрэг биш юм. Хельсинкийн төгсгөлийн баримт бичиг /1975 он/, эсвэл Парисын тунхаглал /1990 он/ шиг улс хоорондын маргаантай асуудлыг улс төрийн аргаар зохицуулах механизм бий болгох гэж энэ бүс нутгийн улс орнууд удаа дараа санал, санаачлага гаргаж байгаа нь үүний илэрхийлэл болно.

Европт хэрэглэсэн түншлэл дээр тулгуурласан аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох ерөнхий зарчмууд Ази, Номхон далайн

бүс нутагт ач холбогдолтой юм. Гэхдээ энэ бүс нутгийн онцлогийг тооцох нь зайлшгүй зүйл болно.

### **Монгол Улсад хамаарах нь:**

Монголын Их гүрэн задран унаснаас хойших олон зуун жилд анх удаа монголчууд төр улсдаа жинхэнэ ёсоор эзэн болж, манай тусгаар тогтнол, газар нутагт харийн цэрэг шууд заналхийлээгүй тийм цаг үетэй бид золголоо. Дэлхийн хоёр туйлт тогтолцооны зөрчил болон хуучин ЗХУ, БНХАУ - ын хооронд үүсч болзошгүй байсан зэвсэгт мөргөлдөөнд татагдан орж гай түйтгэрийн гашуун зовлон амсч мэдэхээр байсан тэр үе нэгэнт түүх болон үлджээ. Гэвч ингэснээр Монгол Улсын аюулгүй байдал найдвартай хангагдаж, бидний газар нутаг аливаа аюулын хөлд хэзээ ч нэрвэгдэхгүй боллоо гэсэн төгс баталгаа бүрэн дүүрэн бий болоогүй байна.

Улсын аюулгүй байдалд цэргийн хүчээр гаднаас шууд нөлөөлөх заналхийлэл учраагүй цоо шинэ нөхцөл байдал үүссэн нь нэг талаас тайвширч болох мэт сэтгэгдэл төрүүлэх боловч, урьд өмнө огт төсөөлж байгаагүй шинэ хүчин зүйлүүд гарах болж, хуучин аюул ч өөр хэлбэрээр эргэж ирэхгүй гэсэн баталгаа бий болоогүй байна.

Монгол Улс газар зүйн байрлалаараа Ази тивийн геостратегийн чухал түшиц нутаг, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, дэлхийн том шашнуудын нөлөөллийн зах нийлсэн зааг дээр оршдог гэдгээ бид байнга санаж байдаг.

Ази тивд ашиг сонирхлоо хадгалахын төлөө өрсөлдсөн том гүрнүүдийн зөрчил тэмцэлдээн, хөрш болон ойр зэргэлдээ орнуудын хоорондын маргаан сөргөлдөөн монголын ард түмний хувь заяанд хүчтэй нөлөө үзүүлж, зарим тохиолдолд эмгэнэлт явдалд хүргэж байсныг бид мартаагүй байна.

Монгол Улын аюулгүй байдал нь дан ганц гадаад орчинд гарсан нааштай өөрчлөлтөөс бус, бас монголын нийгэм - улс төрийн сэтгэлгээний дотоод хувиралтаас ихээхэн шалтгаалж байна.

Улсын хөгжлийн зарим салбар зогсонги байдалд удаан байх, төрд хямрал, нийгмийн ухамсарт тогтворгүй байдал давамгайлах зэрэг нь өнөөдөр Монгол Улсад магадгүй цэргийн аюулаас ч илүү хор хөнөөл учруулж болзошгүй хүчин зүйл гэж ойлгогдох боллоо.

Эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний бүтээгдэхүүний чанарын асуудал, ядуурал, тэрчлэн гадаад ертөнцтэй холбосон орчин үеийн зам харилцаа, холбоо илт үгүйлэгдэж байгаа, хүрээлэн буй орчны асуудал сэтгэл түгшээх болсон зэрэг нь аюулгүй байдлын цэргийн бус хүчин зүйлд нухацтай анхаарахыг шаардаж байна.

### **Орос, Хятадын хүчин зүйл**

1960-аад оноос эхэлсэн хуучин ЗХУ, БНХАУ - ын сөргөлдөөний хүрээнд Монгол Улс тус хоёр их гүрнийг заагласан завсрын бүс болж байлаа. Энэ нь Монгол Улсын газар зүйн байрлалын цэрэг-стратегийн ач холбогдолтой ч бас уялдаатай юм. Гэхдээ ийм байдал зөвхөн ХХ зууны дунд үеэс эхтэй биш бөгөөд Монголыг цэрэг - улс төрийн хувьд эрхшээлдээ байлгах нь Орос, Хятадын аль алинд Азид нөлөөгөө тогтоох чухал түлхүүр болж байсан тухай олон зууны түүх өгүүлдэг билээ.

1990 - ээд оноос эхэлсэн Зөвлөлт - Хятадын, дараа нь ОХУ - Хятадын улс төр, эдийн засаг, цэрэг - стратегийн харилцааны өөрчлөлт нь Монголын аюулгүй байдалд нөлөөлөх цоо шинэ орчин, хүчин зүйлүүдийг бий болгосон юм.

Зөвлөлт - Хятадын дээд хэмжээний уулзалтын 1989 оны тавдугаар сарын хамтарсан мэдэгдэл, түүнээс хойших хоёр талын уулзалт, гэрээ хэлэлцээрүүдээр Монголыг Хятадаас “хамгаалах” Зөвлөлтийн “үүргийг” хүчингүй болгож ОХУ, БНХАУ хоёр бие биеийн эсрэг ямар нэгэн байдлаар, түүний дотор хил залгасан гуравдагч орны газар нутаг, ус, агаарын орон зайг ашиглан хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэхгүй гэж тохиролцсон нь Монгол Улсыг хүрээлсэн аюулгүй байдлын орчин эрс өөрчлөгдөхөд хүргэсэн юм. 1992 онд Оросын цэрэг Монгол Улсаас бүрэн гарч дууссанаар энэ тохиролцоо бодит ажил хэрэг болсон билээ.

Монгол Улсаас хоёр их хөрштэйгээ харилцах бодлого нь 1994 онд Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тулгуурлан хэрэгжиж байна. Энэ үзэл баримтлалаар дэвшүүлсэн тэргүүн цэргийн нэг зорилт нь ОХУ, БНХАУ - тай найрсаг харилцаатай байх явдал бөгөөд ингэхдээ аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, тэнцвэртэй харилцах, сайн хөршийн ёсоор өргөн хамтран ажиллахыг эрмэлзэх явдал юм. Хэрэв манай улсын аюулгүй байдлын ашиг сонирхлыг хөндөөгүй

бол хөрш хоёр орныхоо өөр хоорондын маргаанд хөндлөнгөөс үл оролцох байр суурийг Монгол Улс тууштай баримталж байна.

Тайван цагт өөрийн нутаг дэвсгэр дээр гадаадын цэрэг байрлуулахгүй, дамжуулан өнгөрүүлэхгүй, цэргийн ямар нэг эвсэл холбоонд нэгдэхгүй байх Монгол Улсын бодлого нь хөрш хоёр оронтойгоо адил тэнцвэртэй, найрсаг харилцаатай байхыг чухалчилж байгаагийн илэрхийлэл гэж ойлгогдох ёстой юм.

Сүүлийн үед ОХУ, БНХАУ - ын зүгээс Монгол Улстай олон талт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх, ялангуяа уул уурхайн салбарт идэвхтэй хамтран ажиллах талаар ихээхэн анхаарах боллоо. Үүний зэрэгцээ ОХУ, БНХАУ хоёул Төв Ази болон түүний эргэн тойрны орон зайд олон улсын аюулгүй байдлын шинэ харилцааг бий болгох талаар идэвхтэй чармайлт гаргах болж энэ зорилгоор Төв Азийн орнууд болон Энэтхэг, Пакистан, Иран гэх мэт, үндсэндээ Монгол Улсыг хүрээлсэн буюу ойр зэргэлдээ орших ул орнуудтай идэвхтэй түншлэх арга замыг эрж хайх болсон нь бидний анхаарлыг татаж байгаа болно

### **Зүүн хойд Ази болон зонхилох бусад оронтой харилцах нь:**

Монгол Улсыг хүрээлсэн орон зайд “Хүйтэн дайн”-аас хойш гарсан эрс өөрчлөлт, хөгжлийн цаашдын хандлага нь биднийг ирээдүйн хөгжил, аюулгүй байдлын асуудлаа Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Азийн хүрээнд АНУ - тай идэвхтэй түншлэх бодлогод тулгуурлан авч үзэхэд хүргэж байгаа болно.

Үүнээс үүдэн Зүүн Хойд Азид үүсч бий болсон геополитик, геостратегийн орон зайд Монгол Улсын эзлэх байрыг зөв тодорхойлох нь манай хөгжлийн тулгамдсан чухал асуудал болж байна. Монгол Улсад Орос, Хятадаас гадна АНУ, Зүүн хойд Азийн бусад оронтой идэвхтэй, найрамдалтай, харилцан ашигтай хамтран ажиллах шаардлага бий бөгөөд үүнийг аль хэр ухаалаг, оновчтой, алсын хараатай шийдвэрлэж чадахаас манай аюулгүй байдлын ирээдүй хамаарна гэж бид үзэж байна.

Зүүн хойд Азийн бүс нутагт геополитикийн болон геостратегийн асар их хувьсал гарч байна. Энэ бүс нутагт АНУ, Хятад, Япон, Орос зэрэг дэлхийн том гүрнүүд, эвсэл

бүлгүүдийн эрх ашиг харилцан солбилцож, зарим тохиолдолд харилцан зөрчилдөж байна. Өмнөх түүхээс уламжлагдсан үндэстэн угсаатны зөрчил, газар нутгийн маргаан, хуваагдмал үндэстэн, бие биедээ үл итгэх явдал энэ бүс нутагт хадгалагдсаар байна. Үүний сацуу дэлхийн хөгжлийн төв Ази - Номхон далайн бүс нутаг руу шилжиж байгаа тухай яригдаж, эдийн засгийн “Зүүн Азийн загвар” эрчимжиж байгаа нь энэ бүс нутгийн үүрэг ролийг улам бүр нэмэгдүүлж байна.

- АНУ-тай тогтоосон харилцаа, ялангуяа терроризмтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагаа нь Монголд ардчилалыг хөгжүүлэх, зах зээлийн эдийн засгийг бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах чухал ач холбогдолтой, манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болон хувирч байна. Хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа цаашид стратегийн түншлэлийн хэмжээнд хүртэл гүнзгийрэх бололцоо ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь нэг талаас дэлхийн хамгийн хүчирхэг, нөлөө бүхий гүрний ивээл дор ардчилал, эдийн засаг, нийгмийн хөгжил, аюулгүй байдлын үндсэн асуудлыг амжилттай шийдвэрлэх бололцоог бий болгож байгаа ч нөгөө талаас үүнд хөрш, зэргэлдээ зарим том гүрний зүгээс болгоомжлон хандах болсон нь аюулгүй байдлын гадаад орчны бас нэг шинэ нөхцөл байдлыг үүсгэж байна.
- Японтой тогтоосон иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлсээр байна. Япон улс нь манайд үзүүлж байгаа хандивын зээл, тусламжаараа бусад орныг тэргүүлдэг бөгөөд бид Японы хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээг бууруулахгүй байх зорилтыг тавин ажиллаж байна. Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс зэрэг Ази, Номхон далайн бүс нутгийн том орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгаа бөгөөд үүнийг цаашид улам өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна.
- АСЕАН-ы гишүүн орнууд, Австрали, Шинэ Зеланд, Канадтай тогтоосон улс төрийн харилцааны түвшин ахиж, эдийн засаг, соёлынхамтын ажиллагааны цар хүрээ тэлсээр байна.
- Манай улс Ази, Номхон далайн бүс

нутаг, Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар хоёр талын шугамаар санал солилцох, олон талт яриа хэлэлцээнд идэвхтэй оролцох чиг шугмыг хэрэгжүүлж байна. Монгол Улс 1998 оноос АСЕАН - ны Бүсийн чуулганы / ARF/ гишүүнээр элсэж, олон талт яриа хэлэлцээнд идэвхтэй оролцож байна.

- Монгол Улсад ардчилсан нийгэм байгуулах, зах зээлийн эдийн засгийн харилцааг бэхжүүлэх зорилтыг хангахад Европын орнуудтай тогтоосон харилцаа чухал ач холбогдолтой. Европын Холбоотой түншийн харилцаагаа бэхжүүлж, ХБНГУ, Их Британи, Франц, Итали, Австритай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж байна. Дорнод Европын хуучин социалист болон Скандинавын орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлсээр байна.
- Түүх соёлын уламжлалт хэлхээ холбоотой Төв Азийн орнууд, түүнчлэн Бүгд Найрамдах Турк Улстай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаанд ихээхэн ахиц гарч байна.
- Латин Америкийн орнуудтай олон улсын байгууллагуудын хүрээнд хамтран ажиллахын сацуу тус бүсийн нөлөө бүхий улс орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэл барьж байна.

### **ШХАБ болон НАТО - гийн хүчин зүйл**

Дээр дурьдсанаар БНХАУ, ОХУ - ын зүгээс явуулж буй Төв Ази болон түүний эргэн тойронд орших орон зайд улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ харилцааг бүрдүүлэх оролдлогын нэг тодорхой илэрхийлэл нь улам бүр идэвхжиж буй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын нэгдсэн бодлого, үйл ажиллагаа юм. Энэ байгууллага нь Монгол Улсыг бүрэн хүрээлсэн болон ойр зэргэлдээ орших улс орнуудаас бүрдэж байгаа бөгөөд түүнд цөмийн зэвсэг бүхий том гүрнүүд багтаж байгаа нь бидний зүгээс гадаад орчноо үнэлэхдээ өмнөхөөс өөрөөр хандахыг аргагүй шаардах боллоо.

Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын талаар баримтлах өөрийн гэсэн байр суурьтай болно. ОХУ, БНХАУ - ын зүгээс энэ байгууллагад Монгол Улсыг оролцуулах сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан

боловч бид Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хөгжил, төлөвийг анхааралтай ажиглаж, харзнаж байна. Энэ нь юуны өмнө энэ байгууллага бүрэн төлөвшөөгүй, үүсэн байгуулагдах шатандаа яваа тул түүний хөгжлийн хандлагыг тодорхойлоход тодорхой цаг хугацаа хэрэгтэй юм. Нөгөөтэйгүүр, энэ байгууллагыг голчлон цэрэг, улс төрийн болон аюулгүй байдлын өнцгөөс харах явдал бусад орны хувьд нэлээд түгээмэл байгаатай ч холбоотой болно.

Үүний зэрэгцээ Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хандлага өргөжих төлөвтэй байгааг харгалзан бид энэ байгууллагын талаар баримтлах бодлого, байр суурь, хамтран ажиллах чиглэлээ гүнзгийрүүлэн боловсруулах шаардлага гарч байгааг бас ойлгож байна. Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын өнөөгийн хөгжлийн байдлаас харвал цаашид улс төр, аюулгүй байдлын асуудлын сацуу эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэлийн нэг болгох төлөвтэй байна. Энэ байгууллагын хүрээнд яригдаж эхэлж буй чөлөөт худалдааны бүс, ачаа тээврийн бодлогын зохицуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, байгалийн гамшигтай хамтран тэмцэх, олон улсын терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хар тамхины наймааны эсрэг тэмцэх зэрэг асуудал нь манай улсын ашиг сонирхолтой зайлшгүй холбогдож байгаа юм. Эдгээр үйл явцад хамрагдалгүй үлдвэл бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцаас хоцрох, бүс нутгийг хамарсан томоохон төслүүдийн гадна үлдэх сөрөг тал байгааг бид бас тооцож байгаа болно.

Үүний зэрэгцээ Манай улс өөрийн аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах бодлого, үйл ажиллагааныхаа хүрээнд олон улсын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чиглэлийн нэг том байгууллага болох НАТО - той хамтын ажиллагаа тогтоон хөгжүүлэхийг зорьж, ихээхэн санаачлагатай ажиллахыг чухалчлан үзэж байгаа болно.

НАТО - той харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх талаарх манай бодлогын мөн чанар нь Монгол Улс олон улсын энэ том байгууллагатай хамтран ажиллах улс төр, эрх зүйн үндсийг оновчтой бүрдүүлэх, хөрш хоёр улстайгаа үл ойлголцох байдалд хүргэхгүй байх арга замаар НАТО-ийн "Энхийн төлөө түншлэл" (ЭТТ) хөтөлбөрт оролцож, байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигийн хор уршгийг арилгах, шинжлэх ухаан, байгалын гамшигтай тэмцэх, энхийг сахиулах ажиллагаа, терроризмтэй тэмцэх зэрэг салбарт хамтын

ажиллагаа тогтоон хөгжүүлэхэд оршиж байгаа юм.

### **Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын оролцоо**

Монгол Улсын Их Хурал 1998 онд баталсан "Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс" баримт бичигтээ Зэвсэгт хүчний тайван цагийн нэг чиг үүргийг "НҮБ - ын Энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгүүлэх" гэж тодорхойлсон байдаг. 1999 онд Монгол Улсын Засгийн газрын "Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай" 115 дугаар тогтоол гарч уг тогтоолын дагуу Монгол Улс НҮБ-ын байнгын тогтолцоонд өөрийн хувь нэмрийг оруулах зорилгоор 1999 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хооронд "Харилцан ойлголцлын санамж бичиг" - т гарын үсэг зурсан юм. Энэ үеэс Монгол Улс цэргийн хүчээ НҮБ-ын Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бэлтгэл ажлыг эрчимтэй хийж эхэлсэн юм.

2002 онд "Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" Монгол Улсын хууль батлагдаж тус улсын цэрэг, цагдаагийн албан хаагч, цэрэг, цагдаагийн багийг НҮБ - ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах эрх зүйн үндэс бүрдсэн болно. "Цэрэг цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" Монгол Улсын хуулийн хүрээнд БХЯ, ЗХЖШ - аас Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч, цэргийн багийг энхийг сахиулах болон олон улсын ажиллагаанд оролцох оролцоо, чадавхи боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой зорилго бүхий арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлж ирлээ.

Өнөөгийн байдлаар Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч, цэргийн багууд Сиерра Леон, Ирак, Афганистан, Косово зэрэг дэлхийн халуун цэгүүдэд явагдаж буй НҮБ - ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд үүрэг гүйцэтгэж, бүс нутагт төдийгүй дэлхий дахинаа аюулгүй байдлыг сахин хамгаалах, энх тайван тогтооход өөрийн хувь нэмрийг оруулж байна.

Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч, цэргийн багуудыг НҮБ - ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн бусад ажиллагаанд амжилттай оролцуулсанаар зэвсэгт хүчний



нэр хүнд олон улсын тавцанд болон Монголын ард түмний дунд өсөн нэмэгдэж, цэргийнхний төр, засгийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, итгэл найдвар өсч, цэргийн сургалт бэлтгэлийн чанар, цэргийн албаны гүйцэтгэл сайжран, цэргийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон бүхэлдээ Монгол Улсын Зэвсэгт хүчнийг олон улсын жишигт ойртуулан шинэчлэхэд хүчтэй дэмжлэг болж байна.

### **Дүгнэлт**

Сүүлийн 15 - 17 жилд олон улсын харилцаанд, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын орчин цоо шинээр бүрэлдэн бий болж, урьдын хоёр туйлт хүчний харьцаанаас салж, бүс нутагт уламжлал болж байсан цэрэг-стратегийн тэнцвэр өөрчлөгдсөнөөс болж үйл явцын өрнөл, энх тайван, тогтвортой байдлыг хангах хүчин чармайлтууд огт өөрөөр үнэлэгдэх болж байна.

Манай хөрш хоёр их гүрний хооронд стратегийн түншлэлийн харилцаа хөгжиж, итгэлцэл нэмэгдэж байгаа нь Монгол Улсын хөгжил, аюулгүй байдалд таатай нөхцөл бүрдэх итгэлийг ч мөн төрүүлж байна.

Ийм нөхцөлд Монгол Улс өөрийн аюулгүй байдлыг Орос, Хятадын зэрэгцээ бусад улс оронтой соёлт ертөнцийн хэв хэмжээний хүрээнд харилцах горим журмаар, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын бусад байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хангахыг эрмэлзэж байгаа нь зүй ёсны хэрэг юм.

Ингэснээр Монгол Улсын эвсэлд үл нэгдэх зарчимд тулгуурласан, хоёр их хөрш, АНУ болон дэлхийн нөлөө бүхий бусад гүрэнтэй энх тайвныг эрхэмлэн, нягт хамтран ажиллах, олон улсын аюулгүй байдлыг хангах, терроризмтай тэмцэх хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох чиг шугамыг баримтласан төрийн гадаад бодлого амжилттай хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.



*Др. В.В. Грайворонски*  
*Оросын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахин судлалын*  
*Институтын Монголын хэлтсийн захирал*

## **Орчин үеийн Монгол улсын талаархи Орос улсын баримтлаж буй бодлогын зарим онцлог**

### **Монгол улс: Их гүрнүүдийн ашиг сонирхлын талбар дахь объект**

Хүндэт хурлын дарга аа  
 Хүндэт ноёд, хатагтай нар аа

Юуны урьд тус хуралд миний биеийг урьж манай Орос улсаас өнөөгийн Монгол улсын талаар явуулж байгаа бодлогын тухай хэдэн санал бодлоо илэрхийлж хуваалцах сайхан бололцоог олгосон Конрад Аденауэр Сангийн удирдлага болон бусад зохион байгуулагчдад чин сэтгэлийн баяр талархлаа дэвшүүлье. Тус хурал дээр авч хэлэлцэж буй сэдэв бол цаг үеэ олсон, маш чухал асуудал юм гэж онцлон тэмдэглэмээр байна. Учир нь сүүлийн жилүүдэд Европын холбоо, Монгол улсын хооронд, түүний дотор Герман, Монгол улсын хооронд олон талт харилцаа холбоо, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж, Монгол улсын гадаад бодлогын тэргүүлэх нэг чиглэл болсон төдийгүй мөн Зүүн Хойт Ази болон Ази, Номхон далайн бүс нутагт нөлөөтэй нэг хүчин зүйл болж ирсэн байна.

#### **1990 оноос хойш Монгол улсын гадаад бодлогод болон Орос, Монгол улсын харилцаанд гарсан үндсэн өөрчлөлт**

1980-аад онуудын эцэс - 1990-ээд онуудын эхэнд дэлхийн социалист систем болон ЗХУ задарч оронд нь Оросын Холбооны Улс бий болж, мөн түүнчлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1990 онд тайван замаар ардчилсан хувьсгал болж, шинэ Монгол улс бий болсоноос хойш манай хоёр улсын хоорондын харилцаа болон олон улсын харилцаа эрс

өөрчлөгдөв. Урьдын ЗХУ бол БНМАУ-ын хувьд гадаадын гол тушиг тулгуур, үндэсний аюулгүй байдлын батлан хамгаалах холбоотон, нийгмийн бүтээн байгуулалтын ерөнхий загвар, туслах гол донор улс байсан бол 1990 онуудын өөрчлөлтийн үр дүнд ЗХУ өөрөө задарч түүний үүрэг нь алга болсон, харин ОХУ-лс нь Хятад улсын адил Монгол улсын нэг найрсаг, сайн хөрш улс болов.

Одоо Монгол улс биеэ даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогоо явуулж байна. Тус бодлогын гол зарчим, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга зам зэргийг Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхой зааж, Монгол УИХурлаар 1994 онд батлуулаад хэрэгжүүлж байна. Тэр үзэл баримтлалд Монгол улс үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт хоёр хөрш Орос, Хятад улстай найрсаг, үндсэндээ тэнцвэртэй, сайн хөршийн харилцаагаа тогтоож өргөн хамтын ажиллагаа хөгжүүлэх нь тус улсын гадаад бодлогын нэн тэргүүний зорилт мөн гэж заасан байна. Үүний зэрэгцээгээр Монгол улсаас АНУ, Япон, Европын холбоо, ХБНГУ, БНСУ зэрэг өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүд болон Энэтхэг, Турк зэрэг бусад улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, тэдгээрийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг нь Монголд бий болгон зохистой түвшинд хүргэх бодлого баримталж байна.

Шилжилтийн үед «чочир эмчилгээний» улмаас манай хоёр улс системийн гүнзгий хямралд нэг зэрэг өртөж үйлдвэрлэл, аж ахуй, худалдаа, эдийн засаг, соёл урлаг, шинжлэх ухаан зэрэг хэвийн харилцаа холбоо ихээхэн алдагдаж зарим салбарт бараг тасарсан билээ. ЗХУ-аас Монгол улсад урьд туслаж байсан туслалцаа эрс буурч хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлт 1998 онд 1990 оныхтой харьцуулвал 6 дахин буурсан билээ<sup>1</sup>.

Монгол улсын шилжилтийн хүнд үед нь олон улсын санхүүгийн байгууллага (ОУВС, Дэлхийн банк, Азийн хнгжлийн банк гэх мэт) болон АНУ, Япон, Герман, БНСУ-улс болон бусад өндөр хөгжилтэй зарим улс орон туслаж дэмжиж байснаар байр сууриа бэхжүүлж чадсан юм. Эдгээр улс орнууд Монгол улсад стратеги, геополитик, худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн зэрэг өөрийн ашиг сонирхолтой байна. Ингэснээрээ сүүлийн жилүүдэд Монгол улс Орос, Хятад, АНУ, Япон, Өмнөд Солонгос, Герман зэрэг бусад улс орны анхаарал, санаархал, ашиг сонирхол сүлжилдэн өрсөлдөх объект болж байна. Үүнд тус дөхөм болох хүчин зүйлээс дурьдвал глобалчлал, «хүйтэн дайн»-ны дараа бүрэлдэн бий болсон том гүрнүүдын хоорондын хүчний шинэ харьцаа, тэдгээрийн улс төр, геополитик, стратеги, эдийн засгийн зэрэг бусад ашиг сонирхол, стратегийн бодлого, мөн түүнчлэн Монгол улсын нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого, Азийн төвд, Ази, Европ хоёрыг холбосон зам харилцаан дээр, хоёр том гүрэн – Орос, Хятад улсын хооронд нь орших Монгол улсын өвөрмөц газар зүйн болон геополитик байрлал, түүний нутаг дэвсгэрт шинээр илрүүлсэн буюу илэрч болзошгүй байгалийн их нөөц баялаг (зэс, алт, мөнгө, нүүрс, уран гэх мэт), мөн түүнчлэн эртний нүүдэлчний соёл иргэншил, орчин үеийн үйлдвэржсэн соёл иргэншил болон эртний нүүдэлчний соёлын ховор сонин зохицол зэргийг дурьдаж болох юм.

Монгол улсад нөлөөлөх Орос, Хятад хоёр хүчин зүйлийн хоорондын хуучин харьцаа нь Хятад улсын талд ашигтай өөрчлөгдөөд байна. Хэрэв 1990 оны өмнөх үед БНМАУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийн 80% гаруй ЗХУ-д оногдож байсан бол сүүлийн жилүүдэд Хятад улс Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтэд эзэлсэн хувь болон оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын хэмжэээрээ тэргүүн байранд орж эдийн засгийн нөлөөгөө улам бэхжүүлж байна. Үүний зэрэгцээгээр АНУ, Япон, БНСУ-улс, Европын холбоо, Герман зэрэг бусад орны улс төр, эдийн засаг, соёл

иргэншлийн үр нөлөө мэдэгдэхүйц өссөөр байна.

1990-д оны дунд үеэс эхлэн Орос улс системийн гүнзгий хямралаас гарч, улс төр, эдийн засгийн байдал аажмаар тогтворжиж, гадаад бодлогын зөвхөн өрнөд зүгт давамгайлан чиглэсэн өрөөсгөл талыг залруулж дорнод зүгт бодлогыг идэвхжүүлсэний хирээр Орос, Монголын харилцаанд бий болсон түр зуурын идэвхгүй үеийг арилгах шаардлагатай болсон юм. Үүнд 2000 оны 11-р сард Орос улсын ерөнхийлөгч В.В. Путин Улаанбаатарт албан ёсны аичлал хийж Улаанбаатарын тунхаглалд гарын үсэг зурсан нь тус хоёр улсын бүх талын харилцааг идэвхжүүлж зогсонги байдлаас гаргаж шинэ шатанд гаргахад хүчтэй түлхэц болсон юм.

### **Одоо Орос улсаас Монгол улсын талаар баримталж байгаа бодлогын гол чиглэл**

Одоо Орос улс үндэснийхээ аюулгүй байдлаа дотоод, гадаадын улс төрийн ашиг сонирхолтойгоор үр ашигтайгаар хослуулахыг хичээдэг. Үүнд Оросын Сибир, Алс Дорнодын нутгийг түлхүү хөгжүүлж, Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж байгаа интегралчлах үйл явцад идэвхтэй оролцох явдал онцгой ач холбогдолтой юм. Ази, Номхон далайн бүс нутагт Орос улсын стратегийн гол зорилго бол тус бүс нутгийн бүх улстай тэнцвэржүүлсэн харилцаа тогтоох замаар удаан хугацааны, тогтвортой байдлыг батлан хангах явдал юм<sup>2</sup>.

Өнөөгийн Орос улсын Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд баримтлаж байгаа гадаад бодлогод Монгол улс чухал байр суурь эзэлж стратегийн түнш улс болж байна.

Орос, Монгол хоёр улсыг нягт холбодог олон талт хүчин зүйлсээс дурьдвал хамгийн түрүүнд 3,5 мянга км шахам үргэлжсэн улсын хил; 2) орос, монгол ард түмний хооронд улс төр, худалдаа, эдийн засаг, соёл иргэншил, хүмүүнлэг зэрэг бусад салбаруудыг хамарсан уламжлалт найрамдлын харилцаа; 3) өнгөрсөн XX-р зууны 70 гаруй жилийн дотор амаргүй хувь заяа, жаргал, зовлон, ялалт, ялагдал зэргийг амсаж өнгөрүүлсэн түүх; 4) Одоо

<sup>1</sup> Монгол улсын статистикийн эмхтгэл. Mongolian Statistical Yearbook 2000. Улаанбаатар, 2001, Т.177.

<sup>2</sup> Обзор внешней политики Российской Федерации. [http://www.mid.ru/brp\\_4.nsf/sps/690A2BAF968B1FA4C32572B10304A6E](http://www.mid.ru/brp_4.nsf/sps/690A2BAF968B1FA4C32572B10304A6E)

хоёр улс маань шилжилтийн үеийн хамгийн хүнд саад бэрхшээлийг даван тулаад гол төлөв нэг чиглэл руу, тухайлбал зах зээлийн эдийн засаг, ардчилал руу зэрэг хөгжин дэвшиж, найрамдал, хамтын ажиллагаагаа шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх ижил эрмэлзлэлтэй байгаа.

Орос улсаас Монгол улсын хувьд баримтлах стратегийн бодлогын үзэл баримтлалыг тусгайлан тодорхойлсон албан ёсны баримт бичиг байхгүй боловч уг бодлогын гол санаа, агуулга, стратегийн чиглэл нь хоёр талын гарын үсэг зурсан гол тулгуур баримт бичиг, мөн түүнчлэн манай хоёр улсын удирдагчид, тухайлбал Орос улсын ерөнхийлөгч В.В. Путин, Монгол улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр нараас хэлсэн үг, нийтлэлүүдийг уншиж задлан үзвэл тов тодорхой болно.

Одоогоор дор дурьдсан 3 тулгуур баримт бичиг хүчин төгөлдөр байна. Үүнд:

- 1) ОХУ-лс, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ<sup>3</sup>. Түүнийг 1993 оны 1-р сарын 20-нд Монгол улсын анхны ерөнхийлөгч П. Очирбат, Орос улсын анхны ерөнхийлөгч Б.Н. Ельцины урилгаар Орос улсад албан ёсны анхны айлчлал хийхдээ Москвад гарын үсэг зурсан юм. Одоо эрхэм хүндэт П. Очирбат гуай тус хуралд биечлэн оролцож байгаад нь баяртай байна.
- 2) Улаанбаатарын тунхаглалыг Орос улсын одоогийн ерөнхийлөгч В.В. Путин Монгол улсад албан ёсны айлчлал хийхдээ 2000 оны 11- сарын 14-нд Монгол улсын ерөнхийлөгч Н Багабанди нар гарын үсэг зурсан билээ<sup>4</sup>.
- 3) Москвагийн тунхаглалыг Монгол улсын одоогийн ерөнхийлөгч Н. Энхбаяр Орос улсад албан ёсны айлчлал хийхдээ 2006 оны 12-р сарын 8-нд ерөнхийлөгч В.В. Путинтэй хамтарч гарын үсэг зурсан юм<sup>5</sup>. Эдгээр 3 гол тулгуур баримт бичиг нь хоорондоо нягт уялдаатай, бие биеэ харилцан баяжуулсан бөгөөд одоо манай хоёр улсын харилцааны эрх зүйн үндэс болдог юм.

Москвагийн тунхаглалыг авч үзвэл Орос, Монголын хамтын ажиллагаа хоёр улсын бүрэн тэгш эрхт байдал, харилцан ашигтай байх, нутаг дэвсгэрийн бүхэл бүтэн байдал, дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зэрэг нийтээр зөвшөөрөгдсөн зарчимьолон улсын эрх зүйн хэм хэмжээг хүндэтгэх үндсэн дээр бүхий л салбарт хөгжих ёстой гэжээ<sup>6</sup>.

Мөн Москвагийн тунхаглалд нэг шинэ чухал зүйл орсон байна. Орос, Монгол улс ойрын жилүүдэд хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн шинж чанартай болгож, цар хэмжээг нь тууштай нэмэгдүүлж, агуулгыг нь баяжуулж үр ашгийг нь дээшлүүлэх замаар чанарын шинэ шатанд гаргана гэж тохиролцсон байна<sup>7</sup>.

Москвагийн тунхаглалд одоо Орос, Монгол хоёр улсын хооронд шийдэгдээгүй улс төрийн асуудал байхгүй гэж онцлон тэмдэглэсэн байна. Сүүлийн жилүүдэд манай хоёр улс дээд хэмжээний уулзалтыг тогтворжуулсанаар үр дүн нь дээшилж бүх талын харилцаанд нааштай нөлөө үзүүлж байна.

2003 онд Монгол улсын «их өр»-ийн асуудлыг Монголд нааштай зохицуулж шийдвэрлэсний ачаар хоёр улсын бүх талын хамтын ажиллагааг өсгөн нэмэгдүүлэх шинэ бололцоог нээж өгсөн юм гэжээ.

Хоёр улс бүх талын харилцааныхаа гэрээ, эрх зүй үндсийг төгөлдөршүүлэх ажлаа үргэлжлүүлсээр байна. Саяхан Н. Энхбаярын хийсэн айлчлалын үед төрөл бүрийн салбарт хамтран ажиллах 9 шинэ гэрээ, хөтөлбөр, санамж бичиг, протокол зэргийг байгуулсан билээ.

Тус хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа нь улс төрийн харилцаанаасаа хоцронгүй байна. 1990-д оны эцсийн байдалтай харьцуулахад сүүлийн жилүүдэд худалдаа, эдийн засгийн харилцаанд чамлахааргүй ахиц гарсан байна. Жишээлбэл, өнгөрсөн 2006 онд манай хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлт \$ 592,9 сая болж 2000 оныхтой харьцуулвал 2 дахин, 2005 оныхоос 33%-иар тус тус өссөн байна<sup>8</sup>. Гэхдээ 1990 оныхтой харьцуулвал 2 дахин бага байна. Өөрөөр хэлбэл, 1990-д онд үүссэн хямралыг өдий болтол арилгаж чадаагүй байна. Хоёрдугаарт, манай хоёр улсын гадаад худалдааны тэнцвэрт харьцаа алдагдаад удаж байна. Тухайлбал, 2006 онд Орос улсаас Монгол улсад гаргасан экспортын хэмжээ,

<sup>3</sup> Договор о дружественных отношениях и сотрудничестве между Российской Федерацией и Монголией // Дипломатический вестник, 1993, № 3-4. С. 3-4.

<sup>4</sup> Дипломатический вестник, 2000, № 12. с. 27-29

<sup>5</sup> Московская декларация <http://www.kremlin.ru> 08.12.2006

<sup>6</sup> Мөн тэнд.

<sup>7</sup> Мөн тэнд.

<sup>8</sup> Монгол улсын статистикийн эмхтгэл. Mongolian Statistical Yearbook 2006. Улаанбаатар, 2007. С. 240.

Монголоос Орос руу гаргасан экспортын хэмжээний хоорондын зөрөө \$550 саяд хүрч, буюу 11 дахин их байсан. Энэ нь хоёр гол учир шалтгаантай байна. Нэгт: Монгол улсаас Орос улсад гаргадаг экспортын хэмжээ буурсаар байна. Хоёрт, Орос улсаас Монгол улсад гаргадаг нэг гол бараа болох нефтийн бүтээгдэхүүний дэлхийн үнэ нэмэгдсээр байна. Гадаад худалдааны алдагдлыг багасгах, тэнцвэрт байдлыг хангах гол арга бол Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа ашигт малтмалын шинэ том ордуудыг хамтран эзэмших явдал мөн гэж олон мэргэжилтэн шинжээчид үзэж байна.

Өнгөрсөн 12-р сард В.В. Путин, Н. Энхбаяр нар Москвад уулзахдаа 2010 гэхэд хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээг 1 млрд. ам.долларт хүргэх зорилт дэвшүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын талаархи хамтын ажиллагаа бол хоёр улсын хамтын ажиллагааны нэг чухал чиглэл мөн. 1990-2005 онуудад Орос улсаас Монгол улсын эдийн засгийн 18 салбарт нийт 40 гаруй сая ам. доллар хөрөнгө оруулсны дотор 27,2%-ийг геологи хайгуул, 15,5%-ийг барилга болон барилгын материалын үйлдвэрлэл, 12,3%-ийг санхүүгийн байгууллага, 9,7%-ийг хүнсний үйлдвэр, 6,5%-ийг тээвэр, 6,3%-ийг худалдаа, үйлчилгээ зэрэг салбарт тус тус оруулсан байна<sup>9</sup>. 2006 онд Монгол улсад оросын 100% хувийн буюу тодорхой хувийн хөрөнгө оруулалттай 430 гаруй хамтарсан үйлдвэр ажиллаж байсан.

Сүүлийн жилүүдэд хоёр улсын худалдаа эдийн засгийн харилцаанд үүсч гарсан нэг шинэ зүйл бол оросын зарим томоохон хувийн компаниуд, тухайлбал «Ренова», «Базовый элемент», «Северсталь» гэх мэт, Монголд үйл ажиллагаа явуулах сонирхол нэмэгдэж, зарим нь төлөөлөгчийн газраа нээж уул уурхайн үйлдвэр, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, барилга байгуулалт, тээврийн дэд бүтэц зэрэг бусад салбарт хөрөнгө оруулах гэж байна.

Одоо Орос улсын шилжилтийн үеийн гол саад бэрхшээлийг нефть, байгалийн хий, алт зэрэг бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтийн ачаар үндсэндээ даван туулж, түүний дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 6-7 хувьд хүргэж зөвхөн эх оронд төдийгүй бусад гадаадын орнуудад оруулах хөрөнгө оруулалтын нөөцтэй болоод байна. Нөгөө талаас Монгол оронд Хятад, Америк, Япон, Өмнөд Солонгос, Герман орнуудын компаниуд ирж олон салбарт хамтран ажиллах

сонирхлоо илэрхийлэхээс гадна Монгол улсад олон жил үйл ажиллагаа явуулж Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдтэй өрсөлдөх болж байна. Иймд Орос, Монгол улс хоёр улсын хоорондын харилцаанд чухал ач холбогдол бүхий Орос-Монголын хамтарсан үйлдвэр «Эрдэнэт», «Монголросцветмет» нэгдэл, «Улаанбаатарын төмөр зам»ХНН зэрэг үйлдвэрүүдийг шинэчилж эдийн засгийн үр ашгийг нь дээшлүүлэх нэг адил сонирхолтой байна. Үүнтэй уялдуулан В.В. Путин Н. Энхбаяртай Москвад уулзахдаа нөхцөл бололцоо бүрэлдвэл Оросын талын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг ойрын ирээдүйд 5 млрд ам. долларт хүргэх боломжтой гэж мэдэгдсэн<sup>10</sup>.

Гэхдээ дээрх уулзалтаас хойш хагас жил өнгөрсөн боловч Монгол улсад хөрөнгө оруулалт хийх тааламжтай нөхцөл бүрдээгүй төдийгүй хөрөнгөө нэгэнт оруулсан Оросын зарим компаний ажиллагааг хүндрүүлэх, нэгэнт тохиролцон гаргасан шийдвэрээс татгалзах зэрэг явдал гарч байна. Сүүлийн саруудад Монголд улс төрийн тогтворгүй байдал газар авч байна.

Орос, Монгол улсын худалдаа, эдийн засгийн харилцааны чухал чиглэл нь хоёр улсын хил орчмын болон бүс нутгийн хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл урлаг зэрэг салбаруудын хамтын ажиллагаа юм. Энэ хамтын ажиллагаа нь манай хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 70% гаруй хувийг эзэлж байна. Үүнд Оросын талаас голлон оролцогчид гэвэл Эрхүү муж, Бүгд Найрамдах Буриад Улс, Алтайн хязгаар, Чит муж, Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Алтай Улс зэрэг болно. Сүүлийн жилүүдэд хоёр улсын нийслэл Москва, Улаанбаатар хотын хоорондын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байна. Москвагийн болон Монголын барилгачид Улаанбаатар хотод 1 сая гаруй м<sup>2</sup> орон сууц, үүний дотор «Москва» бичил хороолол барьж 2006 онд ашиглалтанд оруулсан байна.

Манай хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд саад тотгор болж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд гадаад худалдааны алдагдлыг тэнцвэржүүлэх, бүтцийг сайжруулах, тарифын

<sup>9</sup> Эффективное антикризисное управление. Спецвыпуск к официальному визиту Президента Монголии Н. Энхбаяра в Россию. Москва, 2006, № 45-46. С. 9.

<sup>10</sup> ИТАР-ТАСС. Дипкурьер, 2006, № 23, с. 10.

болон тарифын бус саад бэрхшээлийг арилгах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тохиролцсон зүйлийн биелэлтийг хангах үүрэгтэй хоёр улсын яамд, албан газрын хоорондын зохицуулалтанд анхаарах, хоёр улсын иргэд визгүй зорчих журмыг сэргээх зэрэг болно.

2006 оны 12-р сард Орос улсын ерөнхийлөгч В.В. Путин, Монгол улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр нар Орос, Монголын Худалдаа, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааг 2006-2010 онд Хөгжүүлэх Хөтөлбөрт гарын үсэг зурсан байна. Хөтөлбөрийн гол зорилго нь эдийн засгийн хамтын ажиллагааны нөхцлийг сайжруулсанаар хоёр улсын гадаад худалдааны нийт эргэлтийн хэмжээг 2010 он гэхэд 1 млрд. ам. долларт хүргэх зорилготой юм. Уг Хөтөлбөрт худалдаа, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын тухайлбал, дэд бүтэц, тээвэр, замын сүлжээ, түлш, эрчим хүч, харилцаа холбоо, мэдээлийн технологи, геологи, уул уурхайн үйлдвэр, машин үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, барилга байгуулалт, шинжлэх ухаан, технологи, тойрон аялал, байгаль хамгаалал, хил орчмын болон ойр бүс нутгийн хамтын ажиллагаа зэрэг гол чиглэл, зорилт, арга хэлбэрийг тодорхойлон заасан юм.

Боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, технологи, биеийн тамир спорт зэрэг салбарт манай хоёр улсын хамтын ажиллагаа бол олон жилийн уламжлалтай, ихээхэн үр дүнтэй юм. Тус хамтын ажиллагаа нь уналт, зогсонги байдлаас гарч цаашид хөгжих шинэ чиглэл, хэлбэрээр баяжиж байна. Сүүлийн жилүүдэд жил болгон Орос улсын их, дээд сургуульд 1,5 мянган орчим монгол оюутан суралцаж байгаагийн 50 гаруй хувь нь хоёр улсын засгийн газрын хэлэлцээрийн дагуу Орос улсын төсвийн зардлаар суралцаж байна. Дээр дурдсан чиглэлээс гадна манай хоёр улс үйлвэрлэлийн осол, байгалийн гамшиг урьдчилан сэргийлэх, түүний гарз хохирлыг арилгах, боловсон хүч бэлтгэх, байгаль орчинг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах зэрэг бусад салбарт идэвхтэй хамтран ажиллаж байна. Гэхдээ хоёр улсын яам, албан газар хамтын ажиллагааныхаа нөөц бололцоог дутуу ашиглаж, тохиролцсон зарим зүйлийг хойрго биелүүлж байна.

Дээр дурдсныг нэгтгэн дүгнэвэл Орос улсаас Монгол улсын хувьд найрсаг, сайн хөршийн уламжлалт харилцааг стратегийн түншлэлийн түвшинд цаашид хөгжүүлж, бүх талын хамтын ажиллагааг төгөлдөршүүлэн, ялангуяа худалдаа, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлж үр ашигийг нь

дээшлүүлж, олон улсын тавцанд уламжлалт хамтын ажиллагааг бэхжүүлэн цаашид хөгжүүлэх зэрэг гол чиглэлийг баримтлаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.



*Доктор Елена Бойкова  
Дорно дахин судлалын хүрээлэн, Москва*

## **Монгол болон Төв Азид явуулж буй ОХУ-ын стратеги<sup>1</sup>**

### **Төв Ази дахь Оросын байр суурь**

Саяхан болтол Орос Улс Төв Азид урьдын уламжлалт “Зөвлөлт” хэлбэрийн байр сууриа хадгалж ирсэн. Зөвлөлт Холбоот Улс задарснаас хойш олон жилийн туршид энэ бүс нутагт ОХУ-ын баримталж ирсэн стратег шинэ хандлага ажиглагдаагүй бөгөөд энэ талаар онцлох зүйл бараг байсангүй. Гэвч Өрнөдийн орнууд болон Хятад Улс энэ бүс нутагт нэвтэрч байр сууриа бэхжүүлж эхэлмэгц Орос Улс Төв Азийг бүхэлд нь, ялангуяа тус бүс нутгийн байгалийн баялаг, түүхий эдийн асар их нөөц баялгийг алдаж болзошгүйгээ тус улсын эрх баригчид ойлгож эхэлсэн юм.

Сүүлийн үед Төв Азийн талаархи гадаад бодлогынхоо хүрээнд ОХУ-ын хэрэгжүүлж буй алхмууд нь тус бүс нутаг дахь идэвхгүй харилцаанаасаа аажмаар ухарч тэнд сонирхлоо нэмэгдүүлэх байр суурь баримтлах болсныг илтгэн харуулж байна.

Төв Ази, (түүнчлэн Ази тив бүхэлдээ) Оросын гадаад бодлогын стратегийн тэргүүлэх чиглэл болж эхэлсэн. Энэ өнцгөөс нь бид Ерөнхийлөгч Владимир Путины Төв Азийн (Казахстан, Тажикстан, Туркменстан, Узбекистан зэрэг) орнуудын талаар сүүлийн үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзэж болно. ОХУ эдгээр улсуудтай бүс нутгийн аюулгүй байдал; хоёр талын цэрэг-улс төрийн хамтын ажиллагаа; худалдаа-эдийн засгийн (юуны өмнө тээвэр, холбооны салбарын) хамтын ажиллагаа; санхүү, үйлдвэрлэлийн хамтарсан нэгжүүдийг байгуулах замаар аж үйлдвэр-худалдааны бүлэглэлүүдийг хөгжүүлэх; түлш, эрчим хүчний салбарын хамтын ажиллагаа; хилийн хамтын ажиллагаа зэрэг үндсэн чиглэлүүдээр хамтран ажиллах бодлого баримталж байна. Төв Азийн талаар

баримталж буй Оросын эдийн засгийн бодлогын мөн чанар нь прагматик хандлагыг илүүтэй агуулж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл Орос Улс хандивлагчийн байр сууринаас бус өөрийн ашиг сонирхлыг эрэлхийлсэн түншлэгчийн байр сууринаас хандах болсон. ОХУ энэ бүс нутаг дахь өөрийн сонирхлоо батлан хамгаалах-стратегийн зориулалттай объектууд болон эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон дэд бүтцийн байгууламжуудад түлхүү хандуулж байна.

### **ОХУ ба Монгол улс**

Монгол Улсын талаар ОХУ-ын өмнө тулгарч буй асуудлууд энэ бүс нутгийн орнуудтай олон талаараа ижил төстэй юм. Энэ бол урьд нь Оросын хараат байсан орнуудтай харилцаагаа хэрхэн хөгжүүлэх вэ гэсэн ерөнхий асуулт юм. Хуучин ЗХУ задарснаас хойшхи үеийн Орос-Монголын харилцаа нь Орос - хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Төв Азийн улсуудын харилцаатай ерөнхийдөө төстэй байв.

Гэвч Орос, Монгол хоёр орны харилцаа өөрийн гэсэн онцлогтой гэдэгт хэн ч эргэлзэхгүй байх гэж бодож байна. Монгол Улс 1921 оноос Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ)-тай (тухайн үед Төв Азийн орнууд ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд байсан) албан ёсны дипломат харилцаа тогтоосон юм. Түүнээс хойшхи 70 гаруй жилийн хугацаанд Монгол Улс коммунизмыг байгуулж, капитализмтай

<sup>1</sup> Энэхүү судалгааны ажлыг Хүмүүнлэгийн төлөөх Оросын Сангийн дэмжлэгээр хийв. (Төсөл № 06-01-91817a/G)



тэмцэх гэсэн нэгдмэл үзэл суртлын үндсэн дээр ОХУ-тай харилцаагаа хөгжүүлж ирсэн. Орос, Монголын геополитикийн онцлог нь XIX-XX зууны Монголын гадаад бодлогын гол онцлогыг тодорхойлж байсан. Газар зүйн байрлалын үүднээс авч үзвэл Монгол Улсын хувьд гадаад харилцаа холбоогоо хөгжүүлэх өөр сонголт байгаагүй юм. Үнэндээ Хятад, Оросын аль нэгийг түших цорын ганц сонголт Монгол улсад байсан бөгөөд тухайн үед тус улс Оросыг дагах сонголтыг хийсэн юм.

1990-ээд оны эхээр Зөвлөлт-Монголын харилцааны үзэл суртлын тулгуур задран унаснаар хоёр талын харилцааг хуучин хэвээр нь хадгалах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Түүнээс хойш хоёр талын харилцаа зогсонги байдалд орж энэ байдал нилээд удаан хугацааны туршид үргэлжилсэн бөгөөд энэ хугацаанд Монгол Улс эдийн засаг, улс төрийн шинэ түншүүдтэй болж чадсан юм. Хуучин ЗСБНХУ задарснаар Орос-Монголын эдийн засгийн харилцаа бүрэн уналтанд орж, энэ нь Монгол Улс барууны орнууд болон БНХАУ-тай эдийн засгийн харилцаа холбоогоо хөгжүүлэхэд нь хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

Оросын хувьд Зөвлөлт-Монголын хуучин харилцааны “мөнхийн найрамдал нөхөрлөлийн” үзэл сурталд урт удаан хугацааны туршид баригдмал хэвээр байсан ч энэ харилцаагаа цаашид хөгжүүлэх, дэмжих талаар бараг юу ч хийгээгүй юм. Гагцхүү 2006 онд Монголд хийсэн албан ёсны айлчлалынхаа үеэр ОХУ-ын Ерөнхий сайд асан М.Фрадков “манай улс Монгол Улстай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатайгаа ойлгож байна” гэж мэдэгдсэн билээ. Ийнхүү ухаарахад нь манай эрх баригчдад нилээдгүй хугацаа шаардагджээ гэдэг дээр та бүхэн надтай санал нийлнэ гэдэгт би итгэж байна. Монгол-Оросын хоёр талын харилцааны идэвхгүй зогсонги байдлыг эцэс болгож, энэ харилцааг өнөөгийн олон улсын харилцааны зарчмаар хөгжүүлэх цаг аль хэдийнэ ирснийг Оросын тал үнэндээ саяхнаас ойлгож эхэлсэн юм.

Монголын улс төрийн шинэ нөхцөл байдалд зохицоход Оросын хувьд амаргүй, удаашралтай байв. Харин одоо Орос-Монголын харилцаа ирээдүйд хоёр орон стратегийн түншүүд, хамтрагчид болох чиглэлээр шинэ шатандаа аажмаар шилжин ороод байна.

Орос, Монгол хоёр орон өнгөрсөн үеийн түүх, найрсаг харилцаагаараа холбогддог бөгөөд энэ нь шинэ үеийнхэнд уламжлагдаж ирсэн

байдаг. Гэвч 1990-ээд оны эхээр хоёр улсын хооронд үүссэн ноцтой хурцадмал нөхцөл байдал нь хоёр талын харилцаа урсгалаараа явах боломжгүйг харуулсан. Орос, Монголын харилцаа хэвийн болоход 10 орчим жил шаардагдсан бөгөөд хоёр улс бие биедээ хэрэгтэй гэдгийг аль аль тал нь ойлгосон юм. Оросын хувьд цаашдаа Монголын “том ах” нь хэзээ ч байхгүй гэдгээ эцэстээ ухаарсан. Энэ бол маш тодорхой зүйл. Гэхдээ Монгол дахь геополитикийн байр сууриа Орос одоо хэр тодорхойлоогүй байгаа, үүний улмаас хоёр талын харилцаа тогтвортой биш байна. Монголд явуулах эдийн засаг, улс төрийн сонирхлынхоо урт хугацааны стратегийг Орос улс маш тодорхой томъёолох шаардлагатай байгаа юм.

Өөрсдийн боломж чадавхи, төлөв хандлага, төслийн эрсдэлийг бодитоор тооцож, аль аль талын ашиг сонирхолд нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх прагматик аргачлал хоёр орны хувьд магадгүй хамгийн ирээдүйтэй байх болов уу. Монгол дахь сонирхолоо идэвхжүүлэх, үүний дотор хөрөнгө оруулалтын төслийн сонирхлыг төрүүлэх, энэ ашиг сонирхлоо бататган хадгалах, Монголын түншүүдтэйгээ ойлголцоход зөвхөн өөрсдийнх нь хүсэл сонирхол хангалтгүй гэдгийг Оросын эдийн засгийн элитүүд саяхнаас ойлгох болсон юм.

2006 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын ОХУ-д хийсэн айлчлалын хүрээнд Ерөнхийлөгч В.Путинтай хийсэн уулзалтын үеэр Талууд хоёр талын харилцааны цогц асуудлаар ярилцсан бөгөөд яриа хэлэлцээний гол нь худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх асуудалд чиглэгдсэн. Уг айлчлалын дүнд хэд хэдэн баримт бичиг, үүний дотор Москвагийн Тунхаглалд гарын үсэг зурсан билээ. Уг баримт бичигт стратегийн түншлэлийн хэмжээнд хоёр талын харилцааны далайц, үр дүнг нэмэгдүүлэх эрмэлзэлтэй байгаагаа Талууд харилцан нотолсон юм. Айлчлалын мөрөөр хоёр орны цэрэг-улс төрийн харилцаа идэвхжсэнийг ОХУ-ын Гадаад хэргийн сайд болон Зэвсэгт хүчний жанжин штабын Ерөнхий командлагчийн Улаанбаатарт хийсэн айлчлалаас харж болно. Гэхдээ бодит байдалд ОХУ-ын Монгол дахь байр суурь АНУ, БНХАУ-тай харьцуулахад мэдэгдэхүйц сул байгааг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Монгол Улс Төв Азид болон дэлхийд ач холбогдол бүхий байршилд байрладаг. Монгол улс гадаад түншүүдийн анхаарлыг татаж, улмаар ирээдүйтэй түнш нь болж чадсан. Сайн тал нь гэвэл тус улс урьдын адил хоёрхон

хувилбараас сонголт хийх шаардлагагүй болсон, ямар түнштэй ямар харилцаа тогтоох, ямар харилцааг хөгжүүлэх вэ гэдгээ бие даан шийдвэрлэх боломжтой болсон. Өнөөдөр Монгол Улс газар зүйн хувьд өөрийн хил залгаа хоёр хөрш болох ОХУ, БНХАУ-аас гадна АНУ, Япон, Европын Холбооны Улсууд гэсэн илүү чухал ач холбогдолтой стратегийн “хөршүүдтэй” болсон бөгөөд эдгээр хөршүүд нь тус улсад өөр өөрсдийн сонирхлыг хадгалж байна.

Төв Ази дахь Монголын байр суурь, нөлөө тогтвортой өссөөр байна. Ямар түвшинд энэ өсөлт хадгалагдах вэ гэдэг нь Монгол Улсаас өөрөөс нь хамаарах бөгөөд юуны өмнө тус улсын улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, түүний гадаад бодлого, эдийн засгийн гадаад харилцааны чиг хандлагаас шууд хамаарна. Бүс нутаг болон дэлхий дахинд геополитикийн байдал нь тогтворгүй байгаагаас төрийн удирдлагууд нь урт хугацааны гэрээ байгуулах, гарын үсэг зурахад туйлын болгоомжтой ханддаг Тусгаар Улсуудын Хамтын Нийгэмлэгийн гишүүн Төв Азийн орнуудаас ялгаатай нь гэвэл Монгол Улс дотоодын улс төрийн зарим асуудалтай ч гэсэн улс төрийн хувьд харьцангуй тогтвортой орон бөгөөд энэ утгаараа бүс нутгийн тогтвортой байдал гэх мэт олон улсын тулгамдсан асуудлуудаар олон талт арга хэмжээнд идэвхтэй оролцох боломжтой юм.

ОХУ, АНУ, Европын Холбооны орнууд, БНХАУ-тай Монгол Улс идэвхтэй хамтран ажиллах үр дүнтэй хэлбэрүүдийн хувьд авч үзвэл эхний ээлжинд нийгэм, хүмүүнлэгийн салбарт дунд хугацааны, цаашдаа урт хугацааны хамтын ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх нь оновчтой. Ийнхүү дунд хугацаанаас урт хугацаанд шилжих хамтын ажиллагааны хүрээ нь ийм төслийг хэрэгжүүлэх оролцогч талуудын сонирхлын үзүүлэлт, тогтвортой байдлын хүчин зүйл болно.

### **Төв Ази дахь хүчний тэнцвэртэй байдал**

Одоогоор зөвхөн Монгол төдийгүй Төв Ази бүхэлдээ Орос, Хятад, АНУ, Европын Холбооны Улсууд гэсэн дэлхийн зонхилох хүчнүүдийн ашиг сонирхол зэрэгцэн оршиж буй талбар болоод байна. Тус бүс нутагт зөвхөн нэг гадны лидер давамгайлах боломжгүй гэдгийг энэ бүс нутаг дахь өнөөгийн нөхцөл байдал бэлхнээ харуулж байна. Өрсөлдөөн эхний ээлжинд Орос-АНУ-Хятад гэсэн “гурвалжин”-гийн хүрээнд өргөжинө.

Эдгээр хүчнүүд тус бүс нутагт тодорхой асуудлаар харилцан тохиролцоотой бөгөөд үүнийг Москва, Бээжин, Вашингтонд албан бусаар хүлээн зөвшөөрсөн.

ЗХУ задарснаар дэлхий дахинд нэг туйлт хүчний харьцаа тогтоогүй бөгөөд өнөөдөр дэлхий дээр эдийн засаг, санхүү, батлан хамгаалах болон бусад салбарт бүрэн сонирхол нөлөөгөө хадгалж байгаа АНУ гэсэн нэг тэргүүлэгч хүчин давамгайлж байна. Одоогоор дэлхий дахинд олон туйлт хүчний харьцаа хараахан тогтоогүй байна. Барууны зарим ажиглагчид үүнийг нэг ба хагас туйлт хүчний харьцаа хэмээн тодорхойлж байгаа. Гэвч 21 дүгээр зууны бас нэг тэргүүлэгч хүчин болох БНХАУ үлэмж хурдацтай өсөн хөгжиж байна. Өнөөдөр хүчирхэг, тогтвортой энэ улс дэлхий дахинаа олон туйлт хүчний харьцааг бий болгох бодит нөхцлийг бүрдүүлж байна.

АНУ ашиг сонирхлоо Төв Ази ялангуяа Монголд бодитоор бий болгосон. АНУ Төв Азид цэрэг-улс төрийн нөлөөгөө бэхжүүлж байгаа нь тус бүс нутагт геополитикийн гол хүчнүүд хоорондын тодорхой тэнцвэртэй харьцааг хадгалах асуудлыг бий болгож байна.

Өөрийн болон Төв Азийн орнуудын ашиг сонирхлыг харгалзан үзсэний үндсэн дээр тус бүс нутагт эдийн засгийн харилцааны хүрээгээ эергээр өргөжүүлэх нь ОХУ-ын хувьд тус бүс нутаг дахь улс төр-батлан хамгаалах байр сууриа бэхжүүлэх бааз суурь болох төдийгүй энэ үйл ажиллагаанаас улбаатай сөрөг үр дагаварыг Оросод авчрах геополитикийн өөрчлөлт Төв Азид гарахаас сэргийлэх ач холбогдолтой.

Оросын хувьд Төв Ази дахь нөлөөгөө бэхжүүлэх боломж их байна. Гэвч энэ зорилгоор зөвхөн эрчим хүч, цэрэг-улс төрийн хамтын ажиллагаагаа явуулаад зогсохгүй бүс нутгийн хувьд тулгамдсан асуудлаар шийдвэр гаргах үйл явцад ОХУ идэвхтэй оролцох нь чухал. ОХУ-ын оролцох боломжтой хамтарсан шийдвэр гаргалтын үйл явцын жишээнд бүс нутгийн аюулгүй байдал, олон улсын терроризмтэй хийх тэмцэл, бүс нутгийн экологийн асуудал, соёлын харилцаа, хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагаа зэргийг дурдаж болно. Миний бодож байгаагаар хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагаа, үүний дотор олон талт хамтын ажиллагаа үүнд илүү үр дүнтэй. Евроазийн орнуудын интеграцчилагдах үйл явц идэвхжиж байгаа бөгөөд Орос, АНУ, Хятадын аль аль нь энэ үйл явцыг өөрсдийн хяналтанд байлгах

сонирхолтой байгаа. Одоогийн байдлаар АНУ, Хятад хоёр энэ чиглэлээр илүү амжилттай ажиллаж байна. Энэ талаар Орос, Европын Холбооны улсууд хоцронгүй байгаа нь тэдэнд системтэй аргачлал дутагдаж байгаатай холбоотой.

Нөгөөтэйгүүр, Төв Азид бүрэн хариуцлагыг дангаараа үүрэх боломж, чадамж Оросод байхгүй тул АНУ тус бүс нутгаас бүрмөсөн гарч явахыг Орос хүсэхгүй байгаа. Харин Орос АНУ-тай энэ чиглэлээр илүү нааштай хамтран ажиллах бааз суурийг бүрдүүлэх эрмэлзэлтэй байгаа. Үүний нэг тод жишээ нь Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, НАТО-гийн хооронд хамтран ажиллах сонирхолтой байгаа явдал юм.

“Орос-Хятад-Төв Ази” гэсэн системд харилцан ашигтай, иж бүрэн, олон талт хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх нь тус бүс нутгийн хувьд чухал ач холбогдолтой билээ. Төв Азид Орос болон Хятадын эдийн засгийн байр суурийг нэгэн зэрэг бэхжүүлэх үйл явцаар дамжуулан олон улсын үр ашигтай хамтын ажиллагаанд түлхэц үзүүлэхийн тулд Евроазийн эдийн засгийн хамтын ажиллагаа, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, харилцан уялдааг үлэмж сайжруулах шаардлагатай.

Монгол болон Төв Азийн орнуудын байгалийн их баялагт Орос, АНУ, Европын орнууд, Хятад, Японы сонирхол чиглэж байгаа нь тэд (өөрөөр хэлбэл өндөр хөгжилтэй орнууд) зөвхөн түншүүд байгаад зогсохгүй өрсөлдөгчид байж болно гэсэн үг юм. Мэдээж тус бүс нутагт Орос, АНУ, Хятад болон бусад хүчнүүдийн хооронд санал зөрөлдөөнтэй асуудал байсаар байгаа. Геоэдийн засгийн чимээгүй дайн явагдсаар байгаа. Энэ нь гол төлөв эрчим хүчний үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн эх үүсвэрийн төлөөх тэмцэл, эрчим хүчний салбар дахь өрсөлдөөн хэлбэрээр явагдаж байна.

Ийм нөхцөл байдалд тус бүс нутгаас хэн нэгийгээ шахаж гаргах оролдлого хийх нь хэтэрхий харалган, эрсдэлтэй алхам болно. ОХУ болон энэ үйл явцад оролцож буй бусад хүчнүүд энэ нөхцөлд сөргөлдөхөөсөө илүүтэйгээр дэлхий дахинд чухал ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэхэд хамтын хүчин чармайлт гаргах нь чухал байгаа юм.

Өнөөдөр Орос Улс геополитикийн хувьд Төв Азид давамгайлахын төлөө бус байгааг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. В.В. .Путины

мэдэгдсэнчлэн хуучин Зөвлөлтийн харьяанд байсан орнуудад бүтээлч, зуучлагчийн үүрэг гүйцэтгэхийг ОХУ зорьж байгаа. Тэрээр “Бид зөрчилдөөнийг намжаах бүх шийдвэрийг гаргах хариуцлагыг дангаараа хүлээхэд бэлэн биш байгаа, тиймээс үүнийг хүсэхгүй бөгөөд энэ хариуцлагыг хүлээхгүй. Хямралыг намжаах шийдвэр гаргах хариуцлагыг аль нэг тал ОХУ-д дангаар үүрүүлэхийг бид зөвшөөрөхгүй. Ямарваа шийдвэр Оросын шахалтаар гарах нөхцөл байдал үүсгэхийг бид хүсэхгүй байна” хэмээн мэдэгдсэн юм.

Дээр өгүүлсэнчлэн дэлхий дахинд хоёр туйлт (БНХАУ-АНУ) хүчний харьцаа бүхий систем дахин тогтох бодит нөхцөл улам бүр ойртож байна. Улс төр, эдийн засгийн шинэчлэлийн үйл явц өрнөж буй ОХУ тэргүүлэгч хүчний байр сууриа ойрын ирээдүйд эргүүлэн олж авна гэдэг эргэлзээтэй асуудал. Гэсэн хэдий ч тус улс энэ бүс нутгийн хувьд нөлөө бүхий хүчин хэвээр байгаа. Өрнөд, Дорныг холбох гүүр болж зуучлагчийн үүрэг гүйцэтгэх нь Оросын хувьд үр дүнтэй бөгөөд оновчтой хувилбар юм.

### **Бүс нутаг дахь олон улсын хамтын ажиллагаа**

Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд Төв Азид цэрэг-улс төрийн хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхэд Орос Улсын баримталж буй бодлого чиглэж байна. Зарим нэг эргэлзээ байгаа хэдий ч терроризм, хэт даврах үзэл, мансууруулах бодисын наймаа, үндэстэн дамнасан гэмт хэрэг зэрэг бодит аюул заналтай тэмцэх зорилгоор Төв Азийн орнууд ийм хамтын ажиллагаа явуулахад бэлэн байгаа юм.

Хэдийгээр чухал ач холбогдолтой хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс энэ бүс нутгийн тогтвортой байдал шууд хамаарах боловч ОХУ уг төсөл хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцохгүй байна. Үүнд ОХУ-ын үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой асуудлууд болох нэгдмэл аюулгүй байдал, усны эрчим хүчийг ашиглах хамтарсан шийдвэр, үндэстэн хоорондын тээвэр болон бусад асуудал орно.

Төв Ази болон дэлхий дахины геополитикийн нөхцөл байдал байнга хувьсан өөрчлөгдөж байна. Иймээс хоёр болон олон талт хамтын ажиллагаа, юуны өмнө Төв Азийн орнуудад эдийн засгийн сонирхлоо хадгалж буй орнуудын хувьд урт хугацааны гэрээ

хэлэлцээрт үндэслэсэн хамтын ажиллагаа баталгаатай байх шаардлага урган гарч байна.

### Дүгнэлт

Орос, Монгол хоёр улс анд найзууд хэвээр байгаа гэж хэлэх нь өнөөдөр учир дутагдалтай болжээ. Харилцааг шинэ агуулгаар баяжуулж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Дэлхий дахин, бүс нутгийн шинэ нөхцөл байдалд тохирсон хоёр талын харилцааны системтэй аргачлал шаардлагатай бөгөөд ингэхгүйгээр уг харилцаанд ахиц гарах боломжгүй юм. Орос, Монгол хоёр улс стратегийн түншүүд болох боломжтой бөгөөд шаардлагатай, ийм бодит үндэслэл, боломж хоёр талд бий. Миний бодлоор Монголын талаархи мэдээллийн шинэ бодлого боловсруулах явдал Оросын хувьд тэргүүн зэргийн ач холбогдолтой, учир нь оросууд өнөөдөр Чингис хааныг ихэд сонирхдог ч орчин үеийн Монголын тухай маш бага мэдэж байна.

2008 онд Оросод Ерөнхийлөгчийн сонгууль явагдана, харин тус улсын шинэ Ерөнхийлөгчөөр В.В. Путин дахин сонгогдохгүй нь тодорхой. Төрийн тэргүүнээр өөр хүн сонгогдохтой холбогдуулан шинэ төрийн тэргүүн Төв Азийн орнууд, ялангуяа Монгол Улстай урт хугацааны хамтын ажиллагааны зарчмыг үргэлжлүүлэн баримтлах уу? гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү харилцааны шинж чанар, агуулга гадаадын сэтгүүлчид, улс төр судлаачид гишүүнчлэлд нь багтдаг “Валдай” мэтгэлцээний клубын ярилцлага дээр В.В.Путины хийсэн мэдэгдлийн дараах үеийн байдлаа хадгалан үлдэнэ хэмээн найдаж байна. В.В. Путин хэлэхдээ “Миний хувьд түүний (шинээр сонгогдох Ерөнхийлөгчийн) хараат бус, бүтээлч үйл ажиллагааг дэмжихэд өөрөөсөө шалтгаалах бүхнийг хийх болно. Сүүлийн үед хийсэн зүйлсээ би өөрийн гарааг баллахыг хүсэхгүй.” гэсэн юм.

Төв Азийн бүс нутагт Оросын гүйцэтгэх үүрэг роль улам нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд энэ үйл явцыг тасалдуулах бодит боломж байхгүй. Уг үйл явц хэр хурдацтай өрнөхийг тааж хэлэх боломжгүй юм. Хэрэв ОХУ их гүрнийхээ зангарагт нийцсэн эрч хүчтэй, дэс дараатай, системтэй, далайцтай, жинтэй бодлого явуулж чадвал энэ үйл явцын өрнөл хурдасна. Гэхдээ ямар ч тохиолдолд бүс нутгийн аюулгүй байдал, олон улсын терроризм, мансууруулах бодисын хууль бус наймаа зэрэг бэрхшээлтэй асуудлуудыг

ОХУ-ын оролцоогүйгээр шийдвэрлэж чадахгүй. Хэдийгээр Орос Улс дахин хэзээ ч Төв Ази дахь цорын ганц лидер болж чадахгүй ч гэлээ тус бүс нутаг дахь өөрийн манлайллын байр сууриа өөртөө эргүүлж авчирна гэдэгт итгэлтэй байна.

Алсын хараатай гадаад бодлогын жанжин шугамаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд Орос Улс эдийн засаг, батлан хамгаалах, соёл, геополитикийн ашиг сонирхлоо цэгцтэй тодорхойлох шаардлагатай гэдгийг энд давтан хэлэхийг хүсч байна. Энэ бол Монгол болон Төв Азийн орнуудын аль алинд хамааралтай. Эдийн засаг, цэрэг-улс төр, болон бусад салбарт таатай, сонирхол татсан гадаад түнш болох явдал ОХУ-ын зорилго байх ёстой.